



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭГЭЭР ХАЙГУУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ГЭРЭЭЛЭГЧДИЙН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХӨГДСӨН БОЛОН НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ, ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТООЦОО, ХУВААРИЛАЛТАД БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ

АУДИТЫН КОД: СНАГ-2025/08-НА-НА

ГЭРЭЭЛЭГЧДИЙН 2023 ОНД ТАЙЛАГНАСАН ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛААС БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭ, ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫН ЗААЛТТАЙ НИЙЦЭЭГҮЙ 4,944,502.44 АМ.ДОЛЛАРЫН ЗАРДЛЫГ ХАСАЖ, 18,125,221.31 АМ.ДОЛЛАРЫН ЗАРДЛЫГ ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДАЛД ТООЦОН БАТАЛГААЖУУЛАВ

Улаанбаатар хот

2025



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/173

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх" сэдэвт нийцлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Ашигт малтмал, газрын тосны газарт тус тус хүргүүлэхийг Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Ц.Наранчимэг)-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын дарга, тэргүүлэх аудитор (Б.Бундхорол)-т тус тус даалгасугай.

3. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд (Г.Дамдинням), Ашигт малтмал, газрын тосны газар (даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Баянбаатар) -т тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Б.Баттуяа)-т даалгасугай.

5. Аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангахыг Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Ц.Наранчимэг)-т даалгасугай.

6. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивт хүлээлгэн өгөхийг Санхүүгийн аудитын газрын Аудитын менежер (И.Эрдэнэцэцэг)-т үүрэг болгосугай.



С.МАГНАЙСҮРЭН

Z:\Tushaal\2025\EA-In A Tushaal\1225 SAG-1 Docx

1525010096



Монгол Улсын Ерөнхий аудитормын
2025 оны 18 дугаар сарын 30 ний өдрийн
117 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ТОГТООСОН ТӨЛБӨРИЙН АКТ, ӨГСӨН АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

№	Дугаар, огноо	Зөрчлийн утга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Мөнгөн дүн	
				ам.доллар	төгрөг
1	Албан шаардлага 1280/A0160186 СНАГ-2025/08-НА- НА	Тахь ресурс" ХХК-ийн гүйцэтгэх захирал нь өөрийн хувь эзэмшдэг, гүйцэтгэх захирлаар ажилладаг "Наран эрдэс" ХХК-тай 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр 2023/048 дугаартай "Зөвлөх үйлчилгээ"-ний гэрээ байгуулан гүйцэтгэлээр 90.000.00 ам.доллар буюу 314,599,200.00 төгрөг (гурван зуун арван дөрвөн сая таван зуун ерэн есөн мянга хоёр зуу) шилжүүлэхдээ худалдан авах үнэ тогтоогоогүй, санхүүгийн тайланд холбоотой талуудын тодруулгыг бүртгээгүй, сонирхлын зөрчилтэй ажил гүйлгээ хийсэн байна.	Хамаарал бүхий этгээдээс сонирхлын зөрчилтэй бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа Төлөөлөн удирдах зөвлөл эсвэл мэргэжлийн байгууллагаар үнэ тогтоолгох. Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэхдээ холбоотой талуудын мэдээллийг үнэн зөв, бүрэн тайлагнах.	90,000.00	314,599,200.00
2	Албан шаардлага 1281/A0160186 СНАГ-2025/08-НА- НА	Тэлмэн групп ХХК нь Тэлмэн ресурс ХХК-ийн гүйцэтгэх захирлын эзэмшдэг компани бөгөөд КТП-ний угсрах, 250 ква болон 10кв-н агаарын шугамын ажлыг 356,292,109 төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулж Тэлмэн констракшин ХХК-ийн гүйцэтгэх захирал итгэмжлэлгүйгээр гарын үсэг зурж тамга дарсан, Тэлмэн групп ХХК нь цахилгааны ажил хийх тусгай зөвшөөрөлгүй тул Эрчимт цамхаг ХХК-тай дээрх ажлыг 256,418,154.00 төгрөг (хоёр зуун тавин зургаан сая дөрвөн зуун арван найман мянга нэг зуун тавин дөрөв) давхар гэрээлсэн нь	Хамаарал бүхий этгээдээс сонирхлын зөрчилтэй бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа Төлөөлөн удирдах зөвлөл эсвэл мэргэжлийн байгууллагаар үнэ тогтоолгох. Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэхдээ холбоотой талуудын мэдээллийг үнэн зөв, бүрэн тайлагнах.		256,418,154.00

			Компанийн тухай хууль болон санхүүгийн тайланд холбоотой талуудын тодруулгыг бүртгээгүй ТУЗ болон эрх бүхий мэргэжлийн байгууллагаар худалдан авах үнэ тогтоолгоогүй, сонирхлын зөрчилтэй ажил гүйлгээ хийсэн байна.			
3	Албан шаардлага	1282/A0160186 СНАГ-2025/08-НА- НА	Метангаз ресурс ХХК нь Газрын тосны тухай хууль болон Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу байгаль орчны нөхөн сэргээх баталгаа 17,038.83 ам.доллар буюу 58,114,167.09 төгрөг (тавин найман сая нэг зуун арван дөрвөн мянга нэг зуун жаран долоон төгрөг есөн мөнгө) -ыг эскроу дансанд байршуулах.	Байгаль орчны нөхөн сэргээх баталгааны дутуу 17,038.83 ам.доллар буюу 58,114,167.09 төгрөг (тавин найман сая нэг зуун арван дөрвөн мянга нэг зуун жаран долоон төгрөг есөн мөнгө) -ыг эскроу дансанд байршуулах.	17,038.83	58,114,167.09
4	Албан шаардлага	1283/A0160186 СНАГ-2025/08-НА- НА	Смарт-Ойл Монголиа ХХК нь Газрын тосны тухай хууль болон Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу байгаль орчны нөхөн сэргээх баталгаа 610,887.80 ам.доллар буюу 2,083,548,910.58 төгрөг (хоёр тэрбум наян гурван сая таван зуун дөчин найман мянга есөн зуун арван төгрөг тавин найман мөнгө)-ийг эскроу дансанд байршуулаагүй байна.	Байгаль орчныг нөхөн сэргээх баталгаа гаргаагүй Смарт-Ойл Монголиа ХХК нь байгаль орчны нөхөн сэргээх баталгаа 610,887.80 ам.доллар буюу 2,083,548,910.58 төгрөг (хоёр тэрбум наян гурван сая таван зуун дөчин найман мянга есөн зуун арван төгрөг тавин найман мөнгө) -ыг эскроу дансанд байршуулах.	610,887.80	2,083,548,910.58

5	Төлбөрийн акт	201/А0160186СНАГ-2025/08-НА-НА	<p>Чайна голденсий петролиум эксплорэйшн корпорэйшн ХХК-ийн Тариач XV талбайд тухайн жилд гүйцэтгэх хайгуулын ажлын доод хэмжээ 2,156,000.00 ам.доллар буюу 7,353,447,640.00 төгрөг (долоон тэрбум гурван сая тэрбум гурван зуун тавин гурван сая дөрвөн зуун мянга зургаан зуун дөчин төгрөг) -ийг хөрөнгийг төрийн захиргааны байгууллагад төвлөрүүлээгүй байна.</p>	<p>Тухайн жилд гүйцэтгээгүй хайгуулын ажлын доод хэмжээ 2,156,000.00 ам.доллар буюу 7,353,447,640.00 төгрөг (долоон тэрбум гурван зуун тавин гурван сая дөрвөн зуун дөчин долоон мянга зургаан зуун дөчин төгрөг) -ийг нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкинд дахь Аудитын шалгалтын орлогыг 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.</p>	2,156,000.00	7,353,447,640.00
6	Төлбөрийн акт	202/А0160186СНАГ-2025/08-НА-НА	<p>Зон Хэн Юу Тиан ХХК-ийн Галба XI талбайд тухайн жилд гүйцэтгэх хайгуулын ажлын доод хэмжээ 4,505,000.00 ам.доллар буюу 15,365,158,450.00 төгрөг (арван таван тэрбум гурван зуун жаран таван сая нэг зуун тавин найман мянга дөрвөн зуун тавин төгрөг) -ийг гүйцэтгээгүй бөгөөд зарцуулагдаагүй хөрөнгийг төрийн захиргааны байгууллагад төвлөрүүлээгүй байна.</p>	<p>Тухайн жилд гүйцэтгээгүй хайгуулын ажлын доод хэмжээ 4,505,000.00 ам.доллар буюу 15,365,158,450.00 төгрөг (арван таван тэрбум гурван зуун жаран таван сая нэг зуун тавин найман мянга дөрвөн зуун тавин төгрөг) -ийг нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкинд дахь Аудитын шалгалтын орлогыг 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.</p>	4,505,000.00	15,365,158,450.00
			Нийт дүн		7,378,926.63	25,431,286,521.67

Агуулга

<p>Тайланг бэлтгэсэн: Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар Газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Аудитын менежер</p> <p>И.Эрдэнэцэцэг Ахлах аудитор Ш.Наран Аудитор</p> <p>Э.Цэлмэгбаяр</p> <p>Геологийн мэргэжлийн зөвлөх, шинжээч Б.Өнөрбаяр Байгаль орчны мэргэжилтэн зөвлөх, шинжээч Б.Энхбаяр</p> <p>2025 оны 6 дугаар сар Тайланг УАГ-ын цахим сайтаас үзнэ үү. www.audit.mn Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах утас: 261885, 261740</p> <p>Хаяг: Үндэсний аудитын газар Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3 Засгийн газрын ГҮ байр Улаанбаатар хот 15160 Монгол Улс</p>	<p>Товчилсон үгийн жагсаалт.....2</p> <p>Хүснэгтэн мэдээллийн жагсаалт.....2</p> <p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх.....3</p> <p>Аудитын зорилт.....3</p> <p>Аудитын арга зүй.....3</p> <p>Үндсэн мэдээлэл.....4</p> <p>БҮЛЭГ 1: ГЭРЭЭЛЭГЧДИЙН ТАЙЛАГНАСАН ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛААС БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭНИЙ ЗААЛТАД НИЙЦЭЭГҮЙ 4,944,502.44 АМ.ДОЛЛАРЫН ЗАРДЛЫГ ХАСАЖ, ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫГ ДАХИН ТООЦООЛЖ 74,889.03 АМ.ДОЛЛАРЫГ ЗАРДЛЫГ НЭМЖ, ТАЙЛАНТ ОНЫ ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫГ 18,125,221.31 АМ.ДОЛЛАРООР БАТАЛГААЖУУЛЛАА.....</p> <p>1.1. АМГТГ нь гэрээлэгчийн тайлагнасан хайгуул үнэлгээний хөрөнгийн үлдэгдлийг 20,569,125.5 сая төгрөгөөр зөрүүтэй дүгнэж, ирүүлсэн байна.....6</p> <p>1.2. АМГТГ нь үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн хөрөнгө оруулалт, төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлж байгаа боловч гэрээний үүргээ бүрэн биелүүлээгүй, төлөвлөгөө, төсөв батлуулсан ч үйл ажиллагаа явуулаагүй гэрээлэгчдэд тодорхой арга хэмээг авч ажиллаагүй байна.....7</p> <p>БҮЛЭГ 2: АМГТГ НЬ ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ЧИГ ҮҮРГЭЭ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ, БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ БҮРЭН ХАНГУУЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.....13</p> <p>2.1. Гэрээлэгчид хууль болон БХГ-ээр хүлээсэн орон нутгийг хөгжүүлэх урамшуулал, байгаль орчныг нөхөн сэргээх баталгааг хугацаандаа бүрэн төлж байршуулаагүй байна.14</p> <p>2.2. БХГ-ний дагуу тайлант онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгч нар хууль тогтоомж, бүтээгдэхүүн хуваах гэрээний заалттай нийцэхгүй дараах асуудлууд байна. Үүнд:.....13</p> <p>2.3. Өмнөх аудитаар газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдэд тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.....16</p> <p>ДҮГНЭЛТ.....19</p> <p>ЗӨВЛӨМЖ.....20</p> <p>Хавсралт 1 Метангаз ресурс ХХК-ийн "Тавантолгой XXXIII" талбайн ӨНЗ.....21</p> <p>Хавсралт 2 Тахь ресурс ХХК-ийн "Богд IV" талбайн ӨНЗ.....22</p> <p>Хавсралт 3 Тахь ресурс ХХК-ийн "Онги V" талбайн ӨНЗ.....23</p> <p>Хавсралт 4 Тэлмэн ресурс ХХК-ийн "Гурвантэс XXXV" талбайн ӨНЗ.....24</p> <p>Хавсралт 5 Жи Өү Эйч ХХК-ийн "Номгон IX" талбайн ӨНЗ.....26</p> <p>Хавсралт 6 Смарт-Ойл Монголиа ХХК-ийн "Эргэл XII" талбайн ӨНЗ.....27</p> <p>Хавсралт 7 Монголын Алт (МАК) ХХК-ийн "Төхөм- X урд" талбайн ӨНЗ.....28</p> <p>Хавсралт 8 Шунхлай Энержи ХХК-ийн "Сүлэнхээр XXXII" талбайн ӨНЗ.....29</p> <p>Хавсралт 9 Капкорп Монголиа ХХК-ийн "Онги V" талбайн ӨНЗ.....30</p> <p>Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал.....32</p> <p>Хүснэгт 1. АМГТГ-ын 2023 оны гүйцэтгэлийн тайлан, үнэлгээ.....4</p> <p>Хүснэгт 2. Гэрээлэгчийн хайгуул, үнэлгээний хөрөнгө дансанд хуримтлуулан бүртгэсэн зардал.....6</p> <p>Хүснэгт 3. АМГТГ-аас ирүүлсэн тайлан дүгнэлтийн зөрүү.....7</p> <p>Хүснэгт 4. Батлагдсан төлөвлөгөө, төсөв.....7</p> <p>Хүснэгт 5. Аудитаар баталгаажуулсан ӨНЗ-ын дүн.....8</p> <p>Хүснэгт 6. Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт.....16</p>
---	--



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОНС	Байгаль орчны нөхөн сэргээлт
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
ГТБТЖ	Газрын тосны бүртгэл тооцооны журам
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МАК	Монгол алт МАК ХХК
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУИС	Монгол Улсын Их Сургууль
НА	Нийцлийн аудит
НББ	Нягтлан бодох бүртгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХС	Орон нутаг хөгжүүлэх сан
СНАГ	Санхүү, нийцлийн аудитын газар
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ХАБЭА	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуй
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (хуучнаар)
ҮАГ	Үндэсний аудитын газар
ӨНЗ	Өртөг нөхөгдөх зардал

Хүснэгтэн мэдээллийн жагсаалт

Хүснэгт 1	АМГТГ-ын 2023 оны гүйцэтгэлийн тайлан, үнэлгээ
Хүснэгт 2	Гэрээлэгчдийн хайгуул, үнэлгээний хөрөнгө дансанд хуримтлуулан бүртгэсэн зардал
Хүснэгт 3	АМГТГ-аас ирүүлсэн тайлан дүгнэлтийн зөрүү
Хүснэгт 4	Батлагдсан төлөвлөгөө, төсөв
Хүснэгт 5	Аудитаар баталгаажуулсан ӨНЗ-ын дүн
Хүснэгт 6	Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3¹-т заасан бүрэн эрхийн хүрээнд Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2², 37.3³ дахь хэсэг, Улсын Их Хурлын Төсвийн Байнгын Хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны А/108 дугаар тушаалаар баталсан аудитын жилийн төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчийн 2023 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнасан эсэхийг баталгаажуулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэнэ. Үүнд:

- Гэрээлэгч нь 2023 онд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулахдаа оруулсан хөрөнгө оруулалт, санхүүжүүлсэн өртөг нөхөгдөх зардал, батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажлыг холбогдох хууль, тогтоомж болон Бүтээгдэхүүн хуваах гэрээнд нийцүүлж, олон улсын холбогдох стандартын дагуу үнэн зөв бүртгэж тайлагнасан байгаа эсэх;
- Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь холбогдох хууль, тогтоомж болон Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан эрх, үүргээ бүрэн биелүүлж, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлагын хэрэгжилтийг хангаж, зөрчил дутагдлаа арилгаж ажилласан эсэх;

Аудитын хамрах хүрээ:

Аудитад АМГТГ-ын Газрын тос, бүтээгдэхүүний газар, Газрын тосны хайгуулын хэлтэс болон Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан, 2023 онд газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын болон санхүүгийн тайланг хянан шалгаж, төрийн аудитын байгууллагад ирүүлсэн тайлан, дүгнэлтийн хүрээнд тухайн гэрээлэгчдийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримт материалыг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4000, АДБОУС 4001 болон МУЕА-ын 2022 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг баримтлан Газрын тосны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, БХГ болон бусад хууль тогтоомжийн холбогдох зүйл, заалтуудыг шалгуур

¹ Төрийн санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд хуульд заасан болон шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлаар аудит хийх;

² Энэ хуулийн 37.1-д заасны дагуу төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн тайлан, дүгнэлтэд төрийн аудитын байгууллага аудит хийж, баталгаажуулна.

³ Төрийн аудитын байгууллага энэ хуулийн 37.2-т заасан аудитыг гүйцэтгэхдээ хараат бус шинжээч, мэргэжилтэн, аудитын хуулийн этгээдийг оролцуулж болно.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

үзүүлэлт болгон АМГТГ-аас зохих хяналтаа хэрэгжүүлсэн эсэхэд холбогдох мэргэжилтнүүдээс шаардлагатай баримт, материал, лавлагаа тайлбар авах, гэрээлэгчийн гүйцэтгэлийн тайлантай тулгах зэрэг аудитын нарийвчилсан горим, сорилыг хэрэгжүүлэн нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулав.

Үндсэн мэдээлэл:

Ашигт малтмал газрын тосны газрын эрхэм зорилго нь төрөөс геологи, уул уурхай, газрын тосны салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжилд ашигт малтмал, газрын тосны салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд оршино.

Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу 2023 онд үйл ажиллагаа явуулсан гэрээлэгч нарын ӨНЗ-н тайланд газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1⁴-д заасны дагуу АМГТГ нь хяналт шалгалтыг хийсэн дүгнэлт, тайланг ҮАГ-т 2024 оны 11 дугаар сарын 12-ны өдрийн 1/4667 дугаар албан бичгээр ирүүлсэн.

Тус дүгнэлт, тайланд газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын 12 гэрээлэгчийн 14 гэрээт талбайн БХГ-ний ерөнхий мэдээлэл, үйл ажиллагаа явуулсан болон явуулаагүй шалтгаан, үндэслэлийг дурдаж, АМГТГ-аар төлөвлөгөө, төсөв батлуулсан 10 гэрээлэгчийн 12 талбайд хайгуулын ажил гүйцэтгэхээс батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу үйл ажиллагаа явуулж ӨНЗ-ыг тайлагнаж ирүүлсэн 8 гэрээлэгчийн 9 гэрээт талбайн анхан шатны баримтыг үндэслэн хяналт шалгалт хийж, дүгнэсэн байна.

АМГТГ-ын нь 2023 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгч нарын ӨНЗ-н тайланд хяналт, шалгалт хийсэн дүгнэлт, тайландаа гэрээлэгчийн саналыг авч тусгаагүй ҮАГ-т ирүүлсэн тул гэрээлэгч нарын саналыг тусгаж дахин хянаж, дүгнэлт тайланг эцэслэн ҮАГ-т 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр 1/1776 дугаартай албан бичгээр ирүүлсэн.

Ашигт малтмал, газрын тосны газрын 2023 оны гүйцэтгэлийн тайланд “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж нөөцийг өсгөнө” гэж төлөвлөсний дагуу 6 зорилгыг дэвшүүлж, 90.0 хувьтай гүйцэтгэсэн гэж тайлагнасан байна. Үүнд:

Хүснэгт 1. АМГТГ-ын 2023 оны гүйцэтгэлийн тайлан, үнэлгээ

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
8	Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж нөөцийг өсгөх.	2023 онд 10 талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. БХГ-ний 4 төслийг УУХҮЯ-нд хүргүүлсэн, эрлийн ажил гүйцэтгэх 2 гэрээ байгуулсан.	90.0
8.1	Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын талбайд сонгон шалгаруулалт зарлах бэлтгэл ажлыг хангах, захиалга хүлээн авах, гэрээлэгчийг сонгон шалгаруулах, хайгуулын талбайд болон эрлээс хайгуулд шилжиж байгаа талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах	Газрын тосны хайгуулын Хар-Ус II, Шарга III, Нэмэгт VI, Борзон VII, Хонгор VIII, Номгон IX, Цагаан-Элс XIII, Зүүнбаян XIV, Баянхошуу XXII, Цайдам XXVI, Хэрлэнтохой XXVIII талбайн геологийн судалгааны багц материал бэлтгэсэн. УУХҮС-ын тушаалуудыг үндэслэн газрын тосны хайгуулын 15 талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарласан.	100.0

⁴ Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага анхан шатны баримтад үндэслэн гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын болон санхүүгийн тайланг хянан шалгаж, дүгнэлт гаргасан тайлангаа төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

8.2	Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн ажил хийх хүсэлт хүлээн авч хянан санал дүгнэлт гаргах, холбогдох хууль дүрэм журмын шаардлага хангасан хуулийн этгээдтэй эрлийн гэрээ байгуулах	Си Эйч Би Ти Ти ХХК, Коммон макс ХХК-иудас шатдаг чанарын эрлийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулах хүсэлт ирүүлснийг судалж, эрлийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан.	100.0
8.3	Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих	...нийт 10 компанийн 12 төлөвлөгөө, төсвийг батлуулсан. Үүнээс нүүрсний метан хийн хайгуулын 6 талбайд, газрын тосны хайгуулын 3 талбайд хээрийн ажил хийгдэж, өдөр тутмын мэдээг хүлээн хүлээн авч, хяналт тавьж ажилласан.	100.0
8.4	Газрын тос, уламжлалт бус газрын тосны геологи, геофизик, гидрогеологи, геохими, өрөмдлөг, хайгуул, ашиглалттай холбогдсон үйл ажиллагааны анхдагч мэдээлэл, тайлан, материалыг хүлээн авах, хянах, мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, хүлээн авах.	Гэрээлэгчдийн хайгуулын ажлын 56 тайлан материал ирүүлснийг хянаж 48 тайланг хүлээн авч, 8 тайлан хянагдсан байна.	90.0
8.5	Эрлийн гэрээ болон Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, батлагдсан төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлд газар дээр нь хяналт тавих	... Хайгуулын ажил эхлэх, явцын хяналт тавихаар Номгон IX, Төхөм X /хойд/, Эргэл XII, Тавантолгой ХХХIII, Гурвантэс ХХХV, Т 1, Богд IV, Онги V талбайд 5 мэргэжилтэн 87 хоног ажиллаж хяналт тавьж ажилласан.	90.0
8.6	Гэрээлэгч нартай жилийн ажлын уулзалтыг зохион байгуулж 2022 онд хийсэн хайгуулын ажлын үр дүн, 2023 онд хийгдэх хайгуулын ажлын төлөвлөгөө төслийн талаар хэлэлцэж тулгамдаж буй асуудал дээр харилцан санал солилцон, бүтээгдэхүүн хуваах гэрээний тухайн жилийн хэрэгжилтийг дүгнэх	Агентлагийн даргын 2023.01.16-ны өдрийн А/11 дүгээр "жилийн ажлын уулзалт зохион байгуулах тухай" тушаалын дагуу 2023.01.17-ны өдрөөс 2023.03.28-ны өдрийн хооронд газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын 14 талбайн 12 гэрээлэгчтэй жилийн ажлын уулзалтыг зохион байгуулж, БХГ-ний 2022 оны хэрэгжилт, төлөвлөгөөний гүйцэтгэл, 2023 оны төлөвлөгөө, төсвийг хэлэлцсэн.	90.0



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

БҮЛЭГ 1: ГЭРЭЭЛЭГЧДИЙН ТАЙЛАГНАСАН ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛААС БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭНИЙ ЗААЛТАД НИЙЦЭЭГҮЙ 4,944,502.44 АМ.ДОЛЛАРЫН ЗАРДЛЫГ ХАСАЖ, ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫГ ДАХИН ТООЦООЛЖ 74,889.03 АМ.ДОЛЛАРЫГ ЗАРДЛЫГ НЭМЖ, ТАЙЛАНТ ОНЫ ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫГ 18,125,221.31 АМ.ДОЛЛАРООР БАТАЛГААЖУУЛЛАА.

1.1. АМГТГ нь гэрээлэгчийн тайлагнасан хайгуул үнэлгээний хөрөнгийн үлдэгдлийг 20,569,125.5 сая төгрөгөөр зөрүүтэй дүгнэж, ирүүлсэн байна.

1.1.1. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартад нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах үүрэгтэй. Гэтэл тайлант онд үйл ажиллагаа явуулсан 8 гэрээлэгчээс 2 гэрээлэгч болох Тэлмэн Ресурс ХХК, Смарт ойл Монголиа ХХК нь хайгуулын үйл ажиллагааны онцлогийг тусгасан, холбогдох хууль, дүрэм, журам, стандарттай нийцсэн бодлогын баримт бичиг боловсруулж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2⁵ дахь заалттай нийцэхгүй байна.

1.1.2. Смарт-ойл ХХК, Метангаз ресурс ХХК, Тахь ресурс ХХК, Тэлмэн ресурс ХХК - иуд нь толгой компани, хамгийн дээд хяналт тавигч компани, хувь хүний талаарх мэдээлэл болон холбоотой талуудын хооронд хийсэн ажил гүйлгээний талаар Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгээгүй байхад АМГТГ нь дүгнэлт тайландаа энэ талаар тусгаагүй байна.

1.1.3. Гэрээлэгчдийн хайгуул, үнэлгээний хөрөнгө оруулалт данс 2023 оны жилийн эцсийн байдлаар 162,565.2 сая төгрөг болж 23,270.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 2: Гэрээлэгчдийн хайгуул, үнэлгээний хөрөнгө дансанд хуримтлуулан бүртгэсэн зардал

/сая төгрөг/					
№	Гэрээлэгч компани	Талбайн нэр	Эхний үлдэгдэл	Тайлант оны өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл
1	Метангаз ресурс ХХК	Тавантолгой XXXIII	14,928.9	15,991.8	30,920.7
2	Тахь ресурс ХХК	Т I	7,095.6	5,090.8	12,186.4
		Богд IV			
		Онги V			
3	Тэлмэн ресурс ХХК	Гурвантэс XXXV	5,758.1	12,867.8	18,625.9
4	Жи Өү Эйч ХХК	Номгон IX	33,925.4	13,368.2	47,293.6
5	Смарт-Ойл Монголиа ХХК	Эргэл XII	3,624.5	775.7	4,400.2
6	Монголын-Алт (МАК) ХХК	Төхөм X урд	28,413.5	15,330.2	43,743.7
7	Шунхлай Энержи ХХК	Сулинхээр XXXIII	5,305.4	89.2	5,394.6
8	Капкорп Монголиа ХХК	Онги V	40,243.6	- 40,243.6	0.0
9	Макс-Ойл ХХК	Ар-булаг XXIX	0.0	0.0	0.0
10	Түмэн-Ойл ХХК	Баянтүмэн XVII	0.0	0.0	0.0
11	ЗонХэнЮуТиан ХХК	Галба XI	0.0	0.0	0.0
12	Чайна Голденсий петролеум эксплорэйшн корпорэйшн ХХК	Тариач XV	0.0	0.0	0.0
Дүн			139,295.0	23,270.1	162,565.2

Эх сурвалж: Гэрээлэгчийн санхүүгийн тайлан

⁵ Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль, тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

1.1.4. БХГ-ны дагуу 2023 онд газрын тос болон уламжлалт бус газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулсан Метангаз ресурс ХХК, Тахь ресурс ХХК, Тэлмэн ресурс ХХК, Жи Өү Эйч ХХК, Смарт-Ойл Монголиа ХХК, Монголын-Алт МАК ХХК, Шунхлай Энержи ХХК гэсэн 7 гэрээлэгч тайлант онд 63,513.7 сая⁶ төгрөгийн хайгуулын хөрөнгө оруулалт хийж хайгуул, үнэлгээний хөрөнгө дансанд бүртгэсэн байна.

1.1.5. Харин Капкорп Монголиа ХХК нь Онги V талбайн хайгуулын ажлыг зогсоох шийдвэр гаргасан тул тайлант онд байгуулсан 7,191.1 сая төгрөг, өмнөх оны хуримтлагдсан 40,243.6 сая төгрөг, нийт 47,434.7 сая төгрөгийн хуримтлагдсан хайгуул, үнэлгээний хөрөнгийг тайлант үеийн алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

1.1.6. Ашигт малтмал, газрын тосны газар нь гэрээлэгчдийн “Хайгуул, үнэлгээний хөрөнгө” дансны эхний үлдэгдлийг 10,883,681.5 сая төгрөгөөр, тайлант оны өөрчлөлтийг 24,824.2 сая төгрөгөөр, эцсийн үлдэгдлийг 20,569,125.5 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй дүгнэж ирүүлсэн нь Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1⁷ дэх заалттай нийцэхгүй байна.

Хүснэгт 3. АМГТГ-аас ирүүлсэн тайлан дүгнэлтийн зөрүү

/сая төгрөг/

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	тайлант оны өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл
Гэрээлэгч	139,295.0	23,270.1	162,565.2
АМГТГ	11,022,976.5	48,094.4	20,731,690.7
Зөрүү (АМГТГ-Гэрээлэгч)	10,883,681.5	24,824.3	20,569,125.5
Аудит	139,295.0	23,270.1	162,565.2
Зөрүү (АМГТГ-Аудит)	10,883,681.5	24,824.3	20,569,125.5

Эх сурвалж: АМГТГ-ын дүгнэлт

1.1.7 Аудитаар анхан шатны нотлох баримтад үндэслэн тулгалт хийж үзэхэд хайгуул, үнэлгээний хөрөнгийн үлдэгдэл 162,565.2 сая төгрөг байна.

1.2. АМГТГ нь үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт, төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлж байгаа боловч гэрээний үүргээ бүрэн биелүүлээгүй, төлөвлөгөө, төсөв батлуулсан ч үйл ажиллагаа явуулаагүй гэрээлэгчдэд тодорхой арга хэмээг авч ажиллаагүй байна.

1.2.1. Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3⁸-т заасны дагуу АМГТГ нь 11 гэрээлэгчийн 13 гэрээт талбайд нийт 84,972,270.01 ам.долларын хайгуулын ажил төлөвлөгөө, төсвийг баталсан боловч АМГТГ-ын ирүүлсэн дүгнэлт тайланд 12 гэрээлэгчийн 14 талбайн хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг 75,317,304.56 ам.доллар буюу 9,654,965.45 ам.доллороор зөрүүтэй дүгнэсэн байна.

Хүснэгт 4. Батлагдсан төлөвлөгөө, төсөв

/ам.доллар/

№	Гэрээлэгчийн нэр	Талбайн нэр	Батлагдсан төлөвлөгөө, төсөв		Нийт батлагдсан төсөв	Хайгуулын ажлын доод хэмжээ
			Жилийн төлөвлөгөө, төсөв	Нэмэлт өөрчлөлт		
1	Метангаз ресурс ХХК	Тавантолгой XXXIII	14,969,201.40	748,998.80	15,718,200.20	1,500,000.00
	Тахь ресурс ХХК	Т I	780,156.00		780,156.00	350,000.00
2		Богд IV	998,751.00	541,155.00	1,539,906.00	350,000.00

⁶ Санхүүгийн тайланд төгрөгөөр илэрхийлэгдсэн дүн

⁷ Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага анхан шатны баримтад үндэслэн гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын болон санхүүгийн тайланг хянан шалгаж, дүгнэлт гаргасан тайлангаа төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ”

⁸ Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих;



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

		Онги V	964,329.00	394,848.00	1,359,177.00	350,000.00
3	Тэлмэн ресурс ХХК	Гурвантэс ХХХV	4,929,861.00		4,929,861.00	498,500.00
4	Жи Өү Эйч ХХК	Номгон IX	2,754,974.11		2,754,974.11	2,500,000.00
5	Смарт-Ойл Монголиа ХХК	Эргэл XII	24,312,704.69		24,312,704.69	3,410,000.00
6	Монголын-Алт (МАК) ХХК	Төхөм X урд	7,209,163.38	345,000.00	7,554,163.38	6,456,000.00
7	Шунхлай Энержи ХХК	Сулинхээр ХХХIII	10,138,096.00		10,138,096.00	
8	Капкорп Монголиа ХХК	Онги V	2,157,940.00		2,157,940.00	508,600.00
9	Макс-Ойл ХХК	Ар-булаг ХХIX	5,369,490.97		5,369,490.97	440,000.00
10	Түмэн-Ойл ХХК	Баянтүмэн ХVII	4,072,125.56		4,072,125.56	8,416,459.00
11	ЗонХэнЮуТиан ХХК	Галба XI	4,285,475.10		4,285,475.10	4,505,000.00
12	Чайна Голденсий петролеум эксплорэйшн корпорэйшн ХХК	Тариач XV			-	2,156,000.00
Нийт			82,942,268.21	2,030,001.80	84,972,270.01	31,440,559.00

Эх сурвалж: /АМГТГ-ын баталсан гэрээлэгчийн төлөвлөгөө, төсөв. Өтрөг нөхөгдөх болон нөхөгдөхгүй зардал орсон дүн/

1.2.2. Дээрх 12 гэрээлэгчээс “Чайна Голденсий Петролеум Эксплорэйшн Корпорэйшн” ХХК нь тухайн жилийн төлөвлөгөө, төсвийн саналаа ирүүлээгүй, АМГТГ-аар батлуулаагүй байна. Энэ талаар АМГТГ тайлан дүгнэлтэд дурдаагүй бөгөөд гэрээний дагуу арга хэмжээ авч Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3⁹-д заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2.3. Мөн Тэлмэн ресурс ХХК нь Гурвантэс сумын Баясах багийн Иргэдийн нийтийн хурал /ИНХ/-ын тогтоол шийдвэр гараагүйн улмаас Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ /БОННУ/-ний нэмэлт тодотголын ажил тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон. Үүнээс шалтгаалан гэрээлэгч гэрээгээр хүлээсэн тухайн жилийн хайгуулын ажлын доод хэмжээг биелүүлэх боломжгүй нөхцөл бүрдсэнээс талбайн давхцал бүхий газарт “Терра Энержи” ХХК-тай “Хамтын ажиллагааны гэрээ” байгуулан хайгуулын 7 цооног өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэсэн боловч АМГТГ-т урьдчилан мэдэгдэж, нэмэлт төлөвлөгөө, төсөв батлуулаагүй, ажлын техникийн шаардлагыг хянуулаагүй тул АМГТГ-аас 1,369,233.85 ам.долларын зардлыг өртөг нөхөгдөх зардлаас хасаж УАГ-т дүгнэлт тайлан ирүүлсэн байгаа нь төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигч эрх, үүргээ биелүүлэхтэй нь холбогдсон асуудлаар зөвлөгөө, чиглэл өгөх хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, гэрээлэгч БХГ-ээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

1.3. Аудитаар гэрээлэгчийн тайлагнасан өртөг нөхөгдөх зардлын нийт дүнг 18,125,221.31 ам.доллараар баталгаажуулаа.

1.3.1. Тайлант жил хайгуулын үйл ажиллагаа явуулсан 8 гэрээлэгчийн 9 талбайд 22,994,834.72 ам.долларын өртөг нөхөгдөх зардлыг тайлагнасан. АМГТГ гэрээлэгчдийн тайлагнасан ӨНЗ-н тайланг хянаж, холбогдох хууль, журамд нийцээгүй 4,680,817.93 ам.долларын зардлыг ӨНЗ-аас хасаж, захиргааны зардал 810,821.07 ам.доллар, өмнөх оноос шилжиж тооцсон 32,000.00 ам.долларыг нэмж хянаж, дүгнэлт ирүүлсэн байна.

Хүснэгт 5. Аудитаар баталгаажуулсан ӨНЗ-ын дүн:

/ам.доллар/

№	Гэрээлэгч нар	Батлагдсан ӨНЗ-ын төлөвлөгөө төсөв	Гэрээлэгчийн тайлагнасан ӨНЗ-ын дүн	АМГТГ-ын ирүүлсэн тайлан дүгнэлт тайлангаар		Аудитаар		Баталгаажсан ӨНЗ-ын дүн
				Нийт ӨНЗ-аас хасах дүн	Захиргааны зардал ӨНЗ-д нэмэх дүн	ӨНЗ-аас хасах дүн	ӨНЗ-д нэмэх дүн	

⁹ Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

1	Метан газ ресурс ХХК	12,928,268.20	4,280,053.59	57,942.15	168,042.59	294,156.00	-	3,985,897.59
2	Тахь ресурс ХХК /Т1/	676,948.00		-			-	-
	Тахь ресурс ХХК /Богд/	1,368,930.00	905,195.91	59,075.77	39,168.50	62,733.87	-	842,462.04
	Тахь ресурс ХХК /Онги/	1,215,412.00	870,918.08	85,997.78	69,248.59	86,109.61	-	784,808.47
3	Тэлмэн ресурс ХХК	4,770,057.00	4,844,424.65	1,369,233.85	162,225.20	1,483,139.79	-	3,361,284.86
4	Жи Өү Эйч ХХК	2,459,950.91	3,976,110.54	1,545,354.79	107,380.16	1,460,288.82	-	2,515,821.72
5	Смарт-Ойл Монголиа ХХК	23,370,717.53	2,265,054.48	819,599.36	70,159.51	812,882.05	28,230.37	1,480,402.80
6	Монголын Алт (МАК) ХХК	7,019,797.50	3,726,334.00	178,778.38	150,609.40	179,085.41	12,836.60	3,560,085.19
7	Шунхлай Энержи ХХК	9,653,222.00	26,691.92	-	1,271.04	1,271.04	-	25,420.88
8	Капкорп Монголиа ХХК	1,878,101.00	2,100,051.55	564,835.85	4,716.08	564,835.85	33,822.06	1,569,037.76
9	Макс-Ойл ХХК	4,440,586.16		-				-
10	Түмэн-Ойл ХХК	3,911,775.00		-				-
11	ЗонХэнЮуТиан ХХК	4,057,321.58		-				-
12	Чайна Голденсий петролеум эксплорэйшн корпорэйшн ХХК	-		-				-
дүн		77,751,086.88	22,994,834.72	4,680,817.93	842,821.07	4,944,502.44	74,889.03	18,125,221.31

1.3.2. Аудитаар холбогдох хууль, журам, бүтээгдэхүүн хуваах гэрээ, дүгнэлт, тайланд үндэслэн ӨНЗ-ын бодит зарцуулалтад аудитын горим хэрэгжүүлж нийт 4,944,502.44 ам.долларыг өртөг нөхөгдөх зардлаас хасаж баталгаажууллаа. Үүнд:

1. Капкорп Монголиа ХХК нь төлөгдөөгүй 2,515.79 ам.долларыг ӨНЗ-д тайлагнасан нь Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан "Газрын тосны бүртгэл, тооцооны журам" -ын өртөг нөхөгдөх зардалд үл тооцох 3 дугаар бүлгийн 3.1.2-т "нягтлан бодох бүртгэлийн аккрузл суурийн дагуу бүртгэсэн боловч төлөгдөөгүй аливаа зардал" гэсэн заалттай нийцээгүй;
2. Метангаз ресурс ХХК -ний Таван толгой ХХХIII талбайд 2D Сейсмийн программ хангамж DUG биет бус хөрөнгө худалдан авсан ханшийн алдагдал 11.93 ам.долларыг ӨНЗ-д тайлагнасан нь Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан "Газрын тосны бүртгэл, тооцооны журам" -ын өртөг нөхөгдөх зардалд үл тооцох 3 дугаар бүлгийн 3.1.14-т "зээлийн хүүгийн зардал болон зээлтэй холбоотой гарсан бусад зардал, банкны хураамж, валютын ханшийн алдагдал болон ханшийн алдагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор авах арга хэмжээний зардал" гэсэн заалттай нийцээгүй;
3. Монголын Алт (МАК) ХХК нь үндсэн хөрөнгийн элэгдэл 645.32 ам.долларыг ӨНЗ-д тайлагнасан нь Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан "Газрын тосны бүртгэл, тооцооны журам"-ын өртөг нөхөгдөх зардалд үл тооцох 3 дугаар бүлгийн 3.1.22-т "худалдаж авсан өртгөөр өртөг нөхөгдөх зардалд тооцогдсон үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, газрын тосны хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардал" гэсэн заалттай нийцээгүй;
4. Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан "Газрын тосны бүртгэл, тооцооны журам"-ын өртөг нөхөгдөх зардалд үл тооцох 3 дугаар бүлгийн 3.1.3-д "анхан шатны баримтын бүрдэл дутуу, эсхүл зөрчилтэй, гэрээ



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

болон нэхэмжлэлээс зөрүүтэй нэр, дансаар хийсэн гүйлгээ, холбогдох ажлын төлөвлөгөө, төсвийн дагуу зарцуулагдаагүй, хэтрүүлсэн, эсхүл гэрээнд зөвшөөрөөгүй зардал” гэсэн заалтыг зөрчиж 3,891,201.19 ам.долларыг ӨНЗ-д тайлагнасан. Үүнд:

- Метан газр ресурс ХХК-ний Таван толгой ХХХIII талбайд кемпийн ажлын байранд ашиглах 16 ширхэг агаар чийгшүүлэгч 487.35 ам.долларыг анхан шатны баримтын бүрдэл дутуу, тайланд давхар тайлагнасан, туршилтын босоо цооногийн өрөмдлөг хийх өрмийн хошуутай байх шаардлагыг хангаагүй, нэмэлт зардал гаргаж 5,762.34 ам.долларын төсөв хэтрүүлсэн;
- Тахь ресурс ХХК-ний Богд IV талбайд томилолтын зардал 6,502.60 ам.доллар, геологийн мэдээллийн сан бүрдүүлэлт 45,000.00 ам.доллар, мацэрал, витринитийн шинжилгээ 517.57 ам.доллар, контейнер 30.30 ам.доллар, программ хангамж 864.08 ам.долларын зардлыг анхан шатны баримтын бүрдэл дутуу буюу зөрчилтэй;
- Тахь ресурс ХХК-ний Онги V талбайд томилолтын зардал 7,630.99 ам.доллар, геологийн мэдээллийн сан бүрдүүлэлт 45,000.00 ам.доллар, контейнер 3,162.91 ам.доллар бусад 19,451.44 ам.доллар, цалин, бичиг хэрэг, сургалтын зардал 682.98 ам.доллар тус тус баталсан төлөвлөгөө, төсвөөс хэтрүүлж зарцуулсан;
- Тэлмэн ресурс ХХК-ний Гурвантэс ХХХV талбайд байгаль орчныг хамгаалахтай хамааралгүй ажлын зар байршуулсан, усны тоолуур худалдан авсан 86.15 ам.доллар, анхан шатны баримтын зөрчилтэй "Эрчимт цамхаг" ХХК-тай байгуулсан гэрээ 28,355.56 ам.доллар, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, орчны шинжилгээний ажил хийх гэрээний дагуу төлбөр бүрэн хийсэн ч тайлан, төлөвлөгөө боловсруулагдаагүй 3,732.10 ам.доллар, усны шугам хоолой байгуулалт 34,753.03 ам.доллар, ажилчдын кемп байгуулах, ачаа тээвэр, машин түрээс, томилолт, шатахуун 157,341.35 ам.доллар, туршилт олборлолтын 3 цооногийн өрөмдлөг 822,417.21 ам.доллар, цооног хоорондын ус цуглуулах бассейн байгуулалт 38,058.82 ам.доллар, 218.21 ам.доллар тус тус төлөвлөгөө, төсвийг хэтрүүлэн зарцуулсан;
- Жи Өү Эйч ХХК -ний Номгон IX” талбайд генераторын засвар үйлчилгээний зардал 237.60 ам.доллар, гэрээт ажил давхардсан 3,500.81 ам.доллар, ажилчдын томилолтын зардлын дүнгээс 467.04 ам.доллар илүү олгосон, стратиграф үнэлгээний 7 цооногийн өрөмдлөгийн зардал 1,359,416.04 ам.долларыг хэтрүүлсэн;
- Смарт-Ойл Монголиа ХХК-ний “Эргэл XII” талбайд 2022 онд хийсэн 2 хэмжээст чичирхийллийн судалгааны ажлын төлбөрт 262,112.72 ам.доллар, 3 хэмжээст чичирхийллийн судалгааны хээрийн ажил, хээрийн боловсруулалт, топогеодезийн ажил, суурин боловсруулалт 388,921.65 ам.доллар тус тус тайлан мэдээ ирүүлээгүй анхан шатны баримтын бүрдэл дутуу зарцуулсан;
- Монголын Алт (МАК) ХХК-ний Төхөм X урд талбайд жилийн уулзалт хурлын үйл ажиллагаа 1,749.50 ам.долларыг анхан шатны баримтын бүрдэл дутуу, төлөвлөгөө, төсөвт тусгагдаагүй өрөмдлөгийн ажил, зөвлөх үйлчилгээний зардал 175,901.37 ам.долларыг тайлагнасан;
- Капкорп Монголиа ХХК-ний Онги V талбайд томилолтын зардал, машины сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ, түрээс, шатахууны зардал нийт 3,042.20 ам.долларын зардлыг анхан шатны баримтын бүрдэл дутуу зарцуулсан, техникийн ажилчдын цалин болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 475,797.27 ам.долларыг батлагдсан төлөвлөгөө, төсвөөс хэтрүүлэн зарцуулсан;

5.Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан "Газрын тосны бүртгэл, тооцооны журам" -ын өртөг нөхөгдөх зардалд үл тооцох 3 дугаар бүлгийн 3.1.7.-д "Монгол Улс болон гадаад улсад төлсөн албан татвар, хураамж, төлбөр урамшуулал, бусад үйлчилгээний хөлс" гэсэн заалтыг зөрчиж 117,978.22 ам.долларын зардлыг ӨНЗ-д тайлагнасан. Үүнд:

- Смарт-Ойл Монголиа ХХК-ний “Эргэл XII” талбайд тээврийн хэрэгслийн гаалийн хураамж, даатгалын төлбөрт 21,214.73 ам.доллар, хог хаягдлын хураамж 523.66 ам.доллар, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд гадаад мэргэжилтнүүдийн ажлын байрны төлбөрт 32,344.31 ам.долларын зардлыг тус тус тайлагнасан;



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

- Монголын Алт (МАК) ХХК-ний Төхөм Х урд талбайд 2D чичирхийллийн судалгааны зардлын ангиллаас хог хаягдлын үйлчилгээний хураамж 130.00 ам.доллар, усны дүгнэлт гаргуулах хураамж 14.55 ам.доллар, ус ашигласан төлбөр 162.43 ам.долларыг тус тус төлж, тайлагнасан;
- Капкорп Монголиа ХХК-ний Онги V талбайд цооногийн даатгалын төлбөрт 63,579.67 ам.доллар, харилцаа холбооны зардалд 8.87 ам.долларыг тус тус тайлагнасан;

6. Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан "Газрын тосны бүртгэл, тооцооны журам" -ын өртөг нөхөгдөх зардалд үл тооцох 3 дугаар бүлгийн 3.1.12.-т "Монгол Улсын шүүх болон эрх бүхий бусад байгууллагаас ногдуулсан төлбөр, акт, торгууль, алданги, гэрээний талын ашиг сонирхол, олон нийттэй харилцах харилцааг сайжруулах, зар сурталчилгаатай холбогдон гарсан зардал, бусдад өгсөн хандив, тусламж" заалтыг зөрчиж 30,349.66 ам.долларын зардлыг ӨНЗ-д тайлагнасан. Үүнд:

- Тахь ресурс ХХК-ний Богд IV талбайд үйл ажиллагаагаа сурталчлах телевизийн бичлэг хийх зардалд 3,827.08 ам.доллар тайлагнасан;
- Тахь ресурс ХХК -ний Онги V талбайд багийн уулзалт, хандивын зардалд 4,717.00 ам.доллар, үйл ажиллагаагаа сурталчлах телевизийн бичлэг хийх зардалд 1,913.53 ам.доллар тайлагнасан;
- Капкорп Монголиа ХХК-ний Онги V талбайд үйл ажиллагаа сурталчлах орон нутгийн малчидтай уулзалт зохион байгуулахад 19,892.05 ам.доллар зарцуулсан;

7. Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан "Газрын тосны бүртгэл, тооцооны журам" -ын өртөг нөхөгдөх зардалд үл тооцох 3 дугаар бүлгийн 3.1.20. гэрээт талбайд ажил гүйцэтгэсэн боловч газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад холбогдох мэдээ, тайлан, баримт материалыг ирүүлээгүй ажил, үйлчилгээний зардал эсхүл ирүүлсэн боловч холбогдох шаардлагад нийцээгүйн улмаас хүлээн аваагүй ажил, үйлчилгээний зардал" заалтыг зөрчиж 705,992.83 ам.долларыг ӨНЗ-д тайлагнасан. Үүнд:

- Метан газр ресурс ХХК-ний Таван толгой XXXIII талбайд нүүрсний давхраас дахь DFIT хэмжилт, Vista#03 цооногийн DST хэмжилтийн ажил амжилтгүй болсон 256,293.03 ам.доллар, тусгай зөвшөөрөлгүй аж ахуй нэгжээс шатахуун худалдан авалт хийсэн 107.64 ам.доллар, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн үед авсан дээжийг лабораторид шинжлүүлэх ажлын зардлыг нэмэлтээр 216.14 ам.доллар гаргаж тайлан мэдээ ирүүлсэн боловч шаардлагад нийцээгүй;
- Тахь ресурс ХХК-ний Онги V талбайд хийн хэмжилтийн сургалт зохион байгуулсан зөвлөх үйлчилгээний ирүүлсэн тайлан 2,030.67 ам.доллар шаардлагад нийцээгүй;
- Тэлмэн ресурс ХХК-ний Гурвантэс XXXV талбайд 58 тууш км 2 хэмжээт чичирхийллийн ажлын нэмэлт төлөвлөгөө, төсвийг батлуулаагүй 21,468.24 ам.доллар, төлөвлөгөө, төсөвт тусгаагүй хайгуулын өрөмдлөгийн зардал 165,331.70 ам.доллар, цооногийн туршилтын ажил 129,645.29 ам.долларын холбогдох материал ирүүлсэн боловч мэдээ, тайлан нь шаардлага хангаагүй;
- Жи Өү Эйч ХХК-ний Номгон IX" талбайд Говь гео коал ХХК-ний гүйцэтгэсэн 40,355.30 ам.долларын 1:25000 масштабтай геологийн судалгааны ажлын анхдагч баримт, материал тайлангууд холбогдох шаардлага хангаагүй;
- Смарт-Ойл Монголиа ХХК-ний "Эргэл XII" талбайд хээрийн суурин кемп барьж байгуулах болон кемп зохион байгуулалтын зардалд зөвлөх үйлчилгээний ирүүлсэн 90,063.58 ам.долларын тайлан мэдээ шаардлага хангаагүй;
- Монголын Алт (МАК) ХХК-ний Төхөм Х урд талбайд гадаад ажилчдын төлбөр, хураамжийн зардалд 482.24 ам.долларыг тайлагнасан;

8. Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан "Газрын тосны бүртгэл, тооцооны журам" -ын өртөг нөхөгдөх зардалд үл тооцох 3 дугаар бүлгийн 3.1.23.-т "гэрээлэгч, эсхүл оператор компанийн газрын тосны хайгуул,



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

ашиглалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байгаа Монгол Улс болон гадаад улс дахь гүйцэтгэх удирдлага, түүнд үйлчлэх үйлчилгээний захиргааны ажилтнууд болон захиргааны үйл ажиллагаатай холбогдон” дахь заалтыг зөрчиж 30,778.85 ам.долларын зардлыг ӨНЗ-д тайлагнасан; Үүнд:

- Тахь ресурс ХХК-ний Богд IV, Онги V талбайд санхүүгийн программ худалдаж авч нийт 1,948.35 ам.доллар тайлагнасан;
- Тэлмэн ресурс ХХК-ний Гурвантэс ХХХV талбайд хог хаягдлын хураамжид 700.35 ам.доллар, ус ашигласны төлбөрт 548.11 ам.доллар, хотын оффист ажилласан хайгуулын ажилчдын хоолны зардалд 1,244.71 ам.доллар, оффисын 3 өрөөний түрээсийн зардалд 8,446.70 ам.доллар, хайгуулын ажилчдын эрүүл мэндийн үзлэгийн төлбөрт 42.15 ам.доллар тус тус тайлагнасан;
- Жи Өү Эйч ХХК-ний Номгон IX” талбайд толгой компаниас ирсэн гадаад удирдлагын буудлын зардал 147.08 ам.доллар тайлагнасан;
- Смарт-Ойл Монголиа ХХК-ний “Эргэл XII” талбайд захиргааны ажилчдын гадаад мэргэжилтнүүдийн виз, оршин суух зөвшөөрөл, даатгал, эрүүл мэндийн үзлэг, бусад зардалд 17,701.40 ам.долларыг тайлагнасан;

9. Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан "Газрын тосны бүртгэл, тооцооны журам" -ын 2 дах хэсгийн 2.1.16.-д "тухайн жилийн өртөг нөхөгдөх зардлын дүнгээс бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан хувь хэмжээгээр тооцсон захиргааны зардал" гэсэн заалтыг үндэслэн баталгаажуулсан ӨНЗ-ын дүнгээс дахин тооцоолол хийж 165,027.65 ам.долларыг хасаж, 74,889.03 ам.долларыг нэмж тооцов. Үүнд:

- Метан газ ресурс ХХК 31,277.56 ам.доллар, Тахь ресурс ХХК-ний Богд IV 2,987.33 ам.доллар, Онги V 2,576.65 ам.доллар, Тэлмэн ресурс ХХК 70,750.12 ам.доллар, Жи Өү Эйч ХХК -ний 56,164.95 ам.доллар, Шунхлай Энержи ХХК-ний 1,271.04 ам.доллар нийт 165,027.65 ам.долларыг ӨНЗ-аас хасах;
- Капкорп Монголиа ХХК-ний Онги V 33,822.06 ам.доллар, Смарт-Ойл Монголиа ХХК-ний 28,230.37 ам.доллар, Монголын Алт (МАК) ХХК 12,836.60 ам.доллар нийт 74,889.03 ам.долларыг ӨНЗ-д нэмэх;

1.3.3. БХГ-ний дагуу 2023 онд газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулсан 8 гэрээлэгчийн 9 талбайн ӨНЗ-ын тайланд тусгасан зардлыг туслан гүйцэтгэгч нартай байгуулсан гэрээ, гэрээ дүгнэсэн акт, гүйцэтгэсэн ажлын тайлан зэрэг анхдагч болон санхүүгийн анхан шатны нотлох баримтад үндэслэн баталгаажууллаа. (Дэлгэрэнгүй задаргааг хавсралт №1-8)

1.3.4. АМГТГ нь БХГ-ний дагуу хайгуулын ажлыг тогтмол гүйцэтгээгүй, хайгуулын ажлын доод хэмжээг биелүүлээгүй тухайн зөрчлийг удаа дараа давтан гаргаж байгаа “ЗонХэнЮуТиан” ХХК, Чайна Голденсий петролеум эксплорэйшн корпорэйшн ХХК -ыг БХГ-ийн 7 дугаар зүйлийн 7.3.3¹⁰ дахь заалтыг биелүүлээгүй тохиолдолд асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар дүгнэлт, тайланд тусгаагүй байна.

1.3.5. Аудитаар үйл ажиллагаа явуулаагүй Чайна Голденсий петролеум эксплорэйшн корпорэйшн ХХК, ЗонХэнЮуТиан” ХХК-д тайлант жилийн хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлээгүй тул БХГ-ний 7 дугаар зүйлийн 7.3.3-т, заасан арга хэмжээг хэрэгжүүлж, тухайн жилд гүйцэтгэх хайгуулын доод хэмжээгээр төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

¹⁰ Гэрээлэгч нь тухайн жилд гүйцэтгэх хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгээгүй тохиолдолд Газрын тосны тухай хуульд заасан хариуцлага хүлээхээс гадна гүйцэтгээгүй ажилд ногдох зарцуулагдаагүй хөрөнгийг тухайн гэрээт жил дууссанаас хойш 30 (гуч) хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад төлнө.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

БҮЛЭГ 2: АМГТГ НЬ ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ЧИГ ҮҮРГЭЭ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ, БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ БҮРЭН ХАНГУУЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

2.1. Гэрээлэгчид хууль болон БХГ-ээр хүлээсэн орон нутгийг хөгжүүлэх урамшуулал, байгаль орчныг нөхөн сэргээх баталгааг хугацаандаа бүрэн төлж байршуулаагүй байна.

2.1.1. Тахь ресурс ХХК нь 2023 оны орон нутгийг хөгжүүлэх урамшуулал 48,564.00 ам.долларыг дутуу төвлөрүүлсэн нь Газрын тосны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4¹¹ дэх заалтыг зөрчсөн тул аудитаар зөрчлийг арилгуулж, холбогдох орон нутгийн дансанд нөхөн төлүүлсэн. Үүнд:

- Говь-Алтай аймгийн ОНХС-ийн дансанд 18,300.00 ам.доллар;
- Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын ОНХС-ийн дансанд 11,264.00 ам.доллар;
- Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн албан тоотыг үндэслэн Тахь ресурс ХХК нь 19,000.00 ам.долларын урамшууллыг Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд байршуулсныг залруулж, аймгийн ОНХС-ийн дансанд төвлөрүүлсэн.

2.1.2. Тайлант оны байгаль орчны нөхөн сэргээх баталгаа 627,926.66 ам.долларыг дутуу байршуулсан нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.9¹² дэх заалтыг зөрчсөн нөхөн байршуулахаар хугацаатай албан шаардлага өгөв. Үүнд:

- Сمارт-Ойл Монголиа ХХК нь 610,887.80 ам.доллар байршуулаагүй;
- Метангаз ресурс ХХК нь 17,038.83 ам.доллар дутуу байршуулсан;

2.2. БХГ-ний дагуу тайлант онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгч нар хууль тогтоомж, бүтээгдэхүүн хуваах гэрээний заалттай нийцэхгүй дараах асуудлууд байна. Үүнд:

2.2.1. Жи Өү Эйч ХХК нь худалдаж авсан бараа материалыг анхдагч өртгөөр бүртгээгүй, 777.50 ам.долларын татвар шингээж ӨНЗ-аар тайлагнасан нь БХГ-ийн 2.2.2-д "Монгол Улс болон гадаад улсад төлсөн татвар, хураамж"-ийг өртөг нөхөгдөх зардалд тооцохгүй гэж заасантай нийцэхгүй;

2.2.3. Жи Өү Эйч ХХК нь тайлант хугацаанд 45,825.20 ам.долларын бараа материалыг дундаж өртгийн аргаар зарлагдаж тайлагнасан нь БХГ-ний 2 дугаар зүйлийн 2.3.2.2-д "тоног төхөөрөмж, бараа материалын зардлыг нягтлан бодох бүртгэлд эхэлж авсныг эхэлж зарлагдах аргачлалаар бүртгэнэ" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй;

2.2.4. Монголын Алт (МАК) ХХК нь газрын тосны хайгуул ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх хайгуулын 2 дугаар үе шат буюу 5 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа ч гэрээт талбайн тодорхой хэсгийг буцааж өгөх үүргээ биелүүлээгүй нь БХГ-ний 6 дугаар зүйлийн 6.1.1-д "Хайгуулын нэгдүгээр үе шатанд гэрээт талбайн 20-30 хувийг доошгүй хэмжээгээр буцаан өгөх" гэж заасантай нийцэхгүй;

2.2.5. Тэлмэн групп ХХК нь Тэлмэн ресурс ХХК-ийн гүйцэтгэх захирлын эзэмшдэг компани бөгөөд КТП-ний угсрах, 250 ква болон 10кв-н агаарын шугамын ажлыг

¹¹ Орон нутгийг хөгжүүлэх урамшууллыг орон нутгийг хөгжүүлэх санд шилжүүлнэ

¹² Байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг жил бүр төлөвлөгөө батлагдсанаас хойш 60 хоногийн дотор Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулах;



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

356,292,109.00 төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулж Тэлмэн констракшин ХХК-ийн гүйцэтгэх захирал итгэмжлэлгүйгээр гарын үсэг зурж тамга дарсан, Тэлмэн групп ХХК нь цахилгааны ажил хийх тусгай зөвшөөрөлгүй тул Эрчимт цамхаг ХХК-тай дээрх ажлыг 256,418,154.00 төгрөгөөр давхар гэрээлсэн нь Компанийн тухай хууль болон санхүүгийн тайланд холбоотой талуудын тодруулгыг бүртгээгүй мөн Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтыг зөрчсөн зөрчилд албан шаардлага өгөв.

2.2.6. Метан газ ресурс ХХК, Смарт-Ойл Монголиа ХХК-иуд гэрээлэгчийн үйл ажиллагааны хэрэгжилт, хариуцлагад хяналт тавих үүрэг бүхий хамтарсан хороог байгуулаагүй нь БХГ-ний 8 дугаар зүйлийн 8.4.1-д "газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгч нь бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан өдрөөс хойш 180 (нэг зуун наяд) хоногийн дотор Хамтарсан хороог байгуулна. Хамтарсан хорооны гүйцэтгэх ажил, ажиллах журмыг тусгай дүрмээр зохицуулна. Хамтарсан хорооны дүрмийг гэрээний талуудын эрх бүхий төлөөлөл хамтран батална" гэж заасантай нийцэхгүй;

2.2.7. Монголын Алт (МАК) ХХК, Метан газ ресурс ХХК, Смарт-Ойл Монголиа ХХК-иуд тайлант жил гэрээлэгчийн зардлаар суралцсан болон дадлага хийсэн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэгдээгүй нь БХГ-ний 8 дугаар зүйлийн 8.2.6 "Гэрээлэгч нь өөрийн зардлаар Монгол Улсын иргэдийг сургах, дадлага хийлгэх замаар газрын тосны аж үйлдвэрийн бүх шатны боловсон хүчин бэлтгэхэд анхаарч ажиллана" гэж заасантай нийцэхгүй;

2.2.8. Гэрээлэгч нарын тайлагнасан анхдагч материалын бүрдүүлэлт, тайлангийн бичвэр болон хавсралт мэдээлэл эмх цэгцгүй байгаа нь УУС-ын (хуучнаар) 2015 оны 49 дүгээр тушаалаар батлагдсан "Газрын тос ба уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч ба үр дүнгийн тайланд тавих шаардлага"-ын 14 дүгээр зүйлийн 14.1-д "Тайлан, материалыг үдэж, хатуу хавтсаар хавтаслаж хуудас нэг бүрийг дугаарласан байна" гэж заасантай нийцэхгүй;

2.2.9. Монголын Алт (МАК) ХХК, Метан газ ресурс ХХК, Тэлмэн ресурс ХХК, Смарт-Ойл Монголиа ХХК -ний энэ хугацаанд хуулийн дагуу 2 жилд 1 удаа хийгдэх байгаль орчны аудит хийлгээгүй, үйл ажиллагааны хүрээнд хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, хяналт тавих шаардлагуудыг биелүүлээгүй нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1-д "Байгаль орчны аудитыг байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хоёр жил тутам хийлгэж..." гэж заасантай нийцэхгүй;

2.2.10. Жи Өү Эйч ХХК нь хайгуулын талбайг хэсэгчлэн буцааж өгөхтэй холбоотой тухайн цаг үед хүчин төгөлдөр мөрдөж байсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/06 дугаар тушаалыг хэрэгжүүлж газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажил гүйцэтгэх шаардлага үүсээгүй байхад 2023 онд Өндөрхаан трейд ХХК-тай 11,583.38 ам.доллар буюу 39,507,318.33 төгрөг (гучин есөн сая таван зуун долоо мянга гурван зуун арван найман төгрөг гучин гурван мөнгө) -ийн гэрээ байгуулж, гүйцэтгэлийг өртөг нөхөгдөх зардалд тайлагнасан нь Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5.-д "Газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газрыг 5 жилд нэг удаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд заавал хамруулах бөгөөд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход энэхүү баталгааг гаргана" гэж заасантай нийцэхгүй;

2.2.11. Тэлмэн ресурс ХХК-аас БХГ-ний 13 дугаар зүйлийн 13.7-д "..., хайгуулын эхний 3 жилд нүүрсний давхаргын метан хийн чиглэлээр дотоодын их сургуульд



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

жил бүр 1 хүнд магистрын хөтөлбөрт тэтгэлэг олгох ба мөн эхний 3 жилд төрийн захиргааны байгууллагын мэргэжилтнүүдийг нүүрсний давхаргын метан хийн чиглэлээр олон улсын мэргэшсэн сертификат олгох сургалтад хамруулна” гэсэн заалтыг хэрэгжүүлэхээр АМГТГ-т хүсэлт ирүүлснийг үндэслэн АМГТГ-ын даргын шийдвэрээр Газрын тосны хайгуулын хэлтсийн мэргэжилтэн МУИС-д шатах ашигт малтмалын геологич мэргэжлээр магистрын зэрэг хамгаалах тэтгэлэгт хөтөлбөрт суралцуулахаар шийдвэрлэж, 2 жил сургалтын төлбөрийг төлсөн нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй;

2.2.12. МУЗГ-ын 2015 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 104 тогтоолоор баталсан БХГ-ний загварын 8.1.3-т "гэрээлэгч нь үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэж, үнэлгээний ажлын тайлангийн эх хувийг төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө " гэж заасны дагуу гэрээлэгчдийг жил бүр байгаль орчны нарийвчилсан үнэлгээний зардал гаргуулж байгаа нь Байгаль орчны үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3-д "Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт, тухайн сум, дүүргийн Засаг даргын санал болон холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн энэ хуулийн хавсралтад заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албанд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ" заалттай нийцэхгүй;

2.2.13. Тахь ресурс ХХК-ийн гүйцэтгэх захирал нь өөрийн хувь эзэмшдэг, гүйцэтгэх захирлаар ажилладаг Наран эрдэс ХХК-тай "Зөвлөх үйлчилгээ"-ний гэрээ байгуулан гүйцэтгэлээр 90.000.00 (314,599,200.00төгрөг) ам.долларыг Компанийн тухай хуулийн 55.6¹³, 92.1¹⁴, 92.2¹⁵ заалтыг тус тус зөрчиж шилжүүлсэн нь ТУЗ болон эрх бүхий мэргэжлийн байгууллагаар худалдан авах үнэ тогтоолгоогүй, санхүүгийн тайланд холбоотой талуудын тодруулгыг бүртгээгүй зөрчилд албан шаардлага өгөв.

2.2.14. Гэрээлэгч холбогдох хууль болон бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхгүй байгаа нь Газрын тосны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5-д "гэрээлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй ...", 2016 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй Зон Хэн Юу Тиан ХХК-ийн Галба XI талбайн тусгай зөвшөөрлийг 2026 он хүртэл сунгасан нь Газрын тосны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.12-т "Хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгэх үүргээ хоёр буюу түүнээс дээш удаа биелүүлээгүй тохиолдолд хайгуулын хугацааг сунгахгүй" гэж заасантай нийцэхгүй, гэрээ цуцлах хүртэлх эрсдэлийг бий болгож байна.

¹³ Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ энэ хуулийн 55.2-т заасны дагуу эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоохдоо хараат бус үнэлгээний байгууллагын дүгнэлтийг ашиглаж болно.

¹⁴ Энэ хуулийн 89.1-д заасан этгээдийн өөрийн ажиллаж байгаа болон хувьцааных нь хяналтын багцыг эзэмшиж байгаа компанитай хийж байгаа хэлцлийг сонирхлын зөрчилтэй хэлцэл гэх ба сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн гишүүдийн олонхын саналаар гаргана

¹⁵ Сонирхлын зөрчилтэй хэлцлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг энэ хуулийн 55 дугаар зүйлд заасан журмын дагуу төлөөлөн удирдах зөвлөл тогтооно



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

2.3. Өмнөх аудитаар газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдэд тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

2.3.1. Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2022 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 1/436 дугаартай албан бичгээр, төлөвлөгөөний хэрэгжилтийг 2025 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 1/2419 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3.2 Төрийн аудитын байгууллагаас 2015-2023 он хүртэл газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардалд баталгаажуулалт хийх 4 удаагийн аудитаар нийт 41 зөвлөмж, 7 албан шаардлага өгч, 5 төлбөрийн акт тогтоосон байна.

Хүснэгт 6. Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт 4 /ам.доллар/

Үзүүлэлт	Огноо	Аудитын шийдвэр						
		Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		Хэрэгжээгүй үлдэгдэл		
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	хувь
Төлбөрийн акт	2019-2020	1	4,799,703.00	1	533,979.50	1	4,265,723.50	
	2021	2	2,631,374.00	-	-	2	2,631,374.00	
	2022	2	1,875,000.00	1	35,000.00	1	1,840,000.00	
Дүн		5	9,306,077.00	2	568,979.50	3	8,737,097.50	6.0
Албан шаардлага	2019-2020	5	-	4	-	1	-	
	2021	1	-	1	-	0	-	
	2022	1	154,159.00	-	-	1	154,159.00	
Дүн		7	154,159.00	5	-	2	154,159.00	71.0
Зөвлөмж	2015-2016	5	-	5	-	-	-	
	2017-2018	5	-	5	-	-	-	
	2019-2020	12	-	9	-	3	-	
	2021	11	-	7	-	4	-	
	2022	8	-	3	-	5	-	
Дүн		41	-	29	-	12	-	71.0
Нийт дүн		53	9,460,236.00	35	568,979.70	18	8,891,256.30	

2.3.3 Ашигт малтмал, газрын тосны газарт нийт 9,306,077.00 ам.долларын 5 төлбөрийн акт тогтоосноос 568,979.50 ам.долларыг барагдуулж, 8,737,097.50 ам.долларын 4 төлбөрийн акт биелээгүй, хэрэгжилт 6.0 хувьтай байна. Үүнд:

- Тусгай зөвшөөрөл, төлбөр, урамшуулал, үйлчилгээний дэмжлэгийг 2019-2020 онд төлөөгүй Шунхлай Энержи ХХК-ийн 1,511.830.70 ам.доллар, Макс ойл ХХК-ийн 2,753.892.8 ам.доллар, 2020-2021 онд Макс ойл ХХК-ийн Арбулаг ХХИХ 782.267.00 ам.доллар, Монголын алт ХХК-ийн Төхөм-Х урд талбай 681.389.00 ам.доллар, Петроматад ХХК-ийн Матад ХХ талбай 18.377 ам.доллар, Петровис ресурс ХХК-ийн Богд IV, Онги 5, Т-1 талбайнууд 123,008.00 ам.доллар, Метан газ ресурс ХХК-ийн Тавантолгой ХХХIII талбай 7.158.00 ам.доллар нийт 5,877,922.50 ам.доллар;




Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

- Хайгуулын ажлын доод хэмжээг 2020-2021 онд дутуу гүйцэтгэсэн Метангаз ресурс ХХК-ийн 517,230.00 ам.доллар, Жи Өү эйч ХХК-ийн 154,410.00 ам.доллар, Тэлмэн ресурс ХХК-ийн 347,535.00 ам.доллар нийт 1,019,175.00 ам.долларын төлбөр төлөгдөөгүй, шүүхийн маргаантай байгаа бол ЗонХэнЮуТиан ХХК-ийн Галба XI талбай 1,240,000.00 ам.доллар, Чайна голденсий петролиум эксплорэйшн корпорэйшн ХХК-ийн Тариач XV талбай 600,000.00 ам.доллар, нийт 2,859,175.00 ам.долларыг дутуу гүйцэтгэсэн;

График 1. Тогтоосон төлбөрийн акт, барагдуулалт


Тогтоосон төлбөрийн акт/ам.доллар/



■ Тусгай зөвшөөрөл, төлбөр, урамшуулал, үйлчилгээний дэмжлэг

■ Тухайн жилийн хайгуулын доод хэмжээг дутуу гүйцэтгэсэн

Актын барагдуулалт/ам.доллар/



■ Барагдсан ■ Барагдаагүй

2.3.4 Ашигт малтмал, газрын тосны газарт 154,159.00 ам.долларын 7 албан шаардлага өгснөөс 5 албан шаардлага биелж, хэрэгжилт 71.0 хувьтай байна.

2.3.5 Монгол Улсын Ерөнхий сайдад 1, Монгол Улсын Засгийн газарт 2, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад 10, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд 2, Ашигт малтмал, газрын тосны газарт 17, Гэрээлэгч нарт 9, нийт 41 зөвлөмж өгсөн. Үүнээс 29 зөвлөмж биелж, хэрэгжилт 71.0 хувьтай буюу дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй байна. Тухайлбал:

Монгол Улсын Ерөнхий сайдад:

- Төрийн холбогдох байгууллагаас гэрээлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих зохицуулалтыг боловсронгуй болгож, Засгийн газрын 2015 оны 49 дүгээр тогтоолоор баталсан Газрын тос, уламжлалт бус газрын тосны, эрэл хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага журам, 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан Газрын тосны бүртгэл тооцооны журмыг уялдуулан хяналт шалгалтыг тухай бүр хэрэгжүүлж, тайлагнадаг чиг үүрийг нарийвчлах, өртөг нөхөгдөх зардлын тайланд хийсэн хяналт шалгалтын тайланг ТАБ-д ирүүлэх хугацааг тодорхой зааж өгөх, гэрээлэгчийн тайлан хүлээн авч үнэлэх, УУХҮЯ-нд хүргүүлэх хугацааг тус тус цагалбартай болгох;

Монгол улсын Засгийн газарт:

- Засгийн газрын 2015 оны 49 дүгээр тогтоолоор баталсан Газрын тос, уламжлалт бус газрын тосны, эрэл хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага журам болон 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан Газрын тосны бүртгэл тооцооны журмыг уялдуулан өөрчлөлт оруулах талаар өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх;



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад:

- МУЗГ-т хүргүүлсэн зөвлөмжийн хүрээнд 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан Газрын тосны бүртгэл тооцооны журамд өөрчлөлт оруулах;
- АМГТГ-ын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, хууль тогтоомжид заасан төлбөр урамшууллын төвлөрүүлэлт, гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт, ӨНЗ-ыг үнэн зөв бүртгэж, тайлагнасан байдалд байнгын хяналт тавих чиг үүргийн хэрэгжилтийг хангуулах;
- Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7, 36 дугаар зүйлийн 36.1-д тус тус заасан чиг үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах;
- Гэрээлэгч тайлант онд төлөвлөгөө, төсөв батлуулж, тухайн оны ихэнх хугацаанд хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаад “түр зогсолт авах” хүсэлт гаргасан тохиолдолд уг хугацаанд зарцуулсан зардлыг өртөг нөхөгдөх зардалд оруулах эсэх талаар Бүтээгдэхүүн хуваах гэрээнд тодорхой тусгуулах арга хэмжээ авах;

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад:

- Засгийн газрын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн, үйл ажиллагаа явуулаагүй гэрээлэгчдийн бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг хангуулах, санал боловсруулж шийдвэрлэх;
- Төрийн аудитын байгууллагаас тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах;

Ашигт малтмал, газрын тосны газарт:

- Гэрээлэгч болон төрийн захиргааны байгууллагын ажлын уялдаа, хариуцлага, хяналтыг сайжруулж, өмнөх аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангах;

Гэрээлэгч нарт:

- Хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, төсөв батлуулаагүй, үйл ажиллагаа явуулаагүй гэрээлэгчид бүтээгдэхүүн хуваах гэрээний үүргээ биелүүлэх;
- Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, баталгаажуулсан ӨНЗ-ын дүнг санхүүгийн тайлан болон ӨНЗ-ын тайланд залруулж, бүртгэх гэсэн зөвлөмжүүдийг тус тус хэрэгжээгүй дахин давтагдсаар байна.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Гэрээлэгчдийн 2023 онд тайлагнасан өртөг нөхөгдөх зардлаас бүтээгдэхүүн хуваах гэрээний заалтад нийцээгүй 4,944,502.44 ам.долларын зардлыг хасаж, 18,125,221.31 ам.долларын зардлыг ӨНЗ-д тооцон баталгаажууллаа.
2. Чайна голденсий петролиум эксплорэйшн корпорэйшн ХХК-ийн Тариач XV талбай болон Зон Хэн Юу Тиан ХХК-ийн Галба XI талбайд газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул хийхтэй холбоотой хууль болон бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, 2 буюу түүнээс дээш жил хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгээгүй байгаа нь гэрээ цуцлах нөхцөл бүрдсэн байна.
3. Аудитад хамрагдагч 11 гэрээлэгчийн 12 талбайн батлагдсан төлөвлөгөө, төсвийн 30 хувьд ногдох зардал хайгуулын ажилд зарцуулагдсанаас үзэхэд гэрээлэгчдийн төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлд тавих хяналт сул, хүлээн авсан анхдагч баримт бичгийн бүрдэл дутуу, төлөвлөгөө, төсвийг хугацаандаа ирүүлээгүй, тогтмол үйл ажиллагаагаа явуулаагүй гэрээлэгчдэд арга хэмжээ авч ажиллахгүй байгаатай холбоотой байна.
4. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан “Газрын тосны бүртгэл тооцооны журам”-д өөрчлөлт оруулах талаар Засгийн газар болон салбарын яаманд удаа дараа зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй байгаа нь гэрээлэгчийн үйл ажиллагаанд эрсдэл учруулж, тодорхой бус байдлыг бий болгож байна.
5. АМГТГ нь гэрээлэгчийн үйл ажиллагааны тайлан мэдээг хугацаанд нь хянаагүйгээс илэрсэн алдаа зөрчлүүд залруулагдахгүй, дараагийн жилүүдэд давтан гарч байгаа нь аудитын үр дүн гарахгүй, аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт биелэхгүй байна.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллагуудын эрх бүхий албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад:

1. Төрийн холбогдох байгууллагаас гэрээлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих зохицуулалтыг боловсронгуй болгож, Засгийн газрын 2015 оны 49 дүгээр тогтоолоор баталсан Газрын тос, уламжлалт бус газрын тосны, эрэл хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага журам, 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан Газрын тосны бүртгэл тооцооны журмыг уялдуулан өөрчлөлт оруулах;
2. Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул хийхтэй холбоотой хууль болон бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, 2 буюу түүнээс дээш жил хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгээгүй Чайна голденсий петролиум эксплорэйшн корпорэйшн ХХК-ийн Тариач XV талбай болон Зон Хэн Юу Тиан ХХК-ийн Галба XI талбайн гэрээг цуцлах;
3. Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулах, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж заасны дагуу холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох.

Ашигт малтмал, газрын тосны газрын даргад:

1. Гэрээлэгчдэд нягтлан бодох бүртгэлийн стандарт, хяналт шалгалтын шаардлагуудыг бүрэн ойлгуулж, хэрэгжүүлэхэд чиглэсэн мэргэжлийн сургалт, зөвлөгөөг тогтмол явуулах;
2. Тухайн жилийн төлөвлөгөө, төсөв батлуулаагүй, биелэлтийг бүрэн хангаж ажиллаагүй, гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй зөрчил гаргасан гэрээлэгчдийг холбогдох хууль, гэрээний дагуу хариуцлага тооцож ажиллах;
3. Анхдагч материал, тайланг журамд заасан хэлбэрээр эмхэтгэж хавтаслан, хуудас дугаарлалтыг гүйцэтгэхийг шаардаж, баримтын бүрдүүлэлтийг хянах, баталгаажуулах дотоод хяналтын механизмыг сайжруулах, гэрээлэгч компаниудын үйл ажиллагаатай холбоотой гэрээлэгч бүрийн цахим мэдээллийн сан бий болгох;



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Хавсралт 1

Метангаз ресурс ХХК-ийн “Тавантолгой ХХХIII” Талбайн ӨНЗ

/ам.доллар/

№	Зардлын ангилал, төрөл	Гэрээлэгчийн тайлагнасан ӨНЗ-ын дүн	Аудитаар хасагдсан зардал	Аудитаар нэмэгдсэн зардал	2023 оны баталгаажсан ӨНЗ
1	2	3	4	5	6
1.2	Талбайн судалгаа	20,863.27	0.00	-	20,863.27
1.3.1	Стратиграфийн цооногийн өрөмдлөг	1,234,471.73	0.00	-	1,234,471.73
1.3.2	Туршилтын босоо цооногийн өрөмдлөг	523,302.05	5,762.34	-	517,539.71
1.3.3	Туршилтын хэвтээ цооногийн өрөмдлөг	187,877.16	187,877.16	-	0.00
1.3.4	Нэмэлт зардал	64,716.60	0.00	-	64,716.60
1.4.1	2 хэмжээст сейсмийн судалгаа	297,786.93	11.93	-	297,775.00
1.4.4	Цооногийн геофизик	209,391.74	11,840.87	-	197,550.87
1.5	Сорьцлолт	613.22	0.00	-	613.22
1.6.1	Хийн ялгаралтын хэмжилт	13,138.58	0.00	-	13,138.58
1.6.2	Нүүрсний чанарын шинжилгээ	25,081.80	0.00	-	25,081.80
1.6.3	Хийн найрлагын шинжилгээ	5,565.00	0.00	-	5,565.00
1.7.1	Хийн нэвчүүлэх чадамжийн шинжилгээ, гүний даралт, температур DFIT	71,287.50	25,720.00	-	45,567.50
1.7.2	Хийн нэвчүүлэх чадамжийн шинжилгээ, гүний даралт, температур DST	245,567.50	30,855.00	-	214,712.50
1.9.1	Бэхэлгээний яндан 4.5" HWT	62,818.71	0.00	-	62,818.71
1.9.2	Өргөтгөсөн туршилт, үнэлгээний цооногт суурилуулах тоног төхөөрөмж	17,140.83	0.00	-	17,140.83
1.9.3	Туршилтын босоо цооногуудыг тоноглох ажлын төлбөр.	98,736.47	0.00	-	98,736.47
1.1	Суурин боловсруулалт	51,841.05	0.00	-	51,841.05
1.11.1	Байгаль орчны нөхөн сэргээлт	32.65	0.00	-	32.65
1.11.2	БОНС-ийн бусад зардал	10,361.11	216.14	-	10,144.97
Хайгуулын ажлын зардлын дүн		3,140,593.90	262,283.44	-	2,878,310.46
2.1	Үндсэн хөрөнгө худалдан авах зардал	97,677.94	0.00	-	97,677.94
2.3	Цалингийн зардал	441,719.14	0.00	-	441,719.14
2.4	Кемп, катеринг	173,196.47	0.00	-	173,196.47
2.5	ХАБЭА, хангамжийн материал, шатахуун	96,322.91	595.00	-	95,727.91
2.6	Тээврийн зардал	32,437.89	0.00	-	32,437.89
2.7	Сургалтын зардал		0.00	-	0.00
Үйл ажиллагааны зардлын дүн		841,354.35	595.00	-	840,759.35
3.1	Туршилтын ажиглалт-шинжилгээ	33,110.97	0.00	-	33,110.97
3.2	Бэхэлгээний яндан 4" HWT	23,931.85	0.00	-	23,931.85
3.3	Хийн агуулга, найрлага, нүүрсний чанар, изотермийн шинжилгээ	37,250.44	0.00	-	37,250.44
Өмнөх оны төлөвлөгөө, төсөв дэх ажилд зарцуулсан нийт дүн		94,293.26	0.00	-	94,293.26
Нийт хайгуулын зардлын дүн		4,076,241.51	262,878.44	-	3,813,363.07
4	Захиргааны зардлын дүн	203,812.08	31,277.56	-	172,534.52
4.1	Эхний 2 сая ам.дол 5%	101,906.04	1,906.04	-	100,000.00
4.2	Дараагийн 2 сая ам.дол 4%	101,906.04	29,371.52	-	72,534.52
Өртөг нөхөгдөх зардлын нийт дүн		4,280,053.59	294,156.00	-	3,985,897.59



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Хавсралт 2

Тахь ресурс ХХК-ийн “Богд IV” талбайн ӨНЗ

/ам.доллар/

№	Зардлын ангилал, төрөл	Гэрээлэгчийн тайлагнасан ӨНЗ-ын дүн	Аудитаар хасагдсан зардал	Аудитаар нэмэгдсэн зардал	2023 оны баталгаажсан ӨНЗ
1	2	3	4	5	6
1.1.1	Геологийн мэдээллийн сан бүрдүүлэлт, тайлалт, менежмент	41,241.43	30,000.00	-	11,241.43
1.1.2.1	Өрөмдлөгийн ажлын зардал	368,863.50	0.00	-	368,863.50
1.1.2.2	Цооногийн геофизикийн ажил	36,571.69	0.00	-	36,571.69
1.1.2.3	Цооногийн туршилт(IFOT)	17,242.50	0.00	-	17,242.50
1.1.3.1	Техникийн бүрэн шинжилгээ	8,380.11	0.00	-	8,380.11
1.1.3.2	Мацерал, Витринитийн шинжилгээ	7,953.18	4,921.39	-	3,031.79
1.1.3.3	Хийн шинжилгээ	43,484.65	0.00	-	43,484.65
1.1.4.1	Хээрийн лаборатори ашиглалтын зардал	36,300.00	0.00	-	36,300.00
1.1.4.2	Хийн хэмжилтийн сургалт, зөвлөх үйлчилгээ	4,061.34	2,031.34	-	2,030.00
1.1.4.3	Канистр дахь чөлөөт хий цэвэрлэх гели	1,794.53	0.00	-	1,794.53
1.1.5.2	2D сейсмийн судалгааны хээрийн мэдээлэл цуглуулах, хээрийн боловсруулалт	142,260.00	0.00	-	142,260.00
1.1.6	Болзошгүй эрсдлийн зардал	10,991.79	5,097.07	-	5,894.72
	Хайгуулын ажлын зардлын дүн	719,144.72	42,049.80	-	677,094.92
1.2.1	Цалингийн зардал	56,023.81	0.00	-	56,023.81
1.2.2	Бичиг хэргийн зардал	2,295.18	1,406.28	-	888.90
1.2.3	Тээвэр	12,103.73	0.00	-	12,103.73
1.2.4	Бараа материалын худалдан авалт	41,511.62	2,108.60	-	39,403.02
1.2.5	ХАБЭА зардал	3,357.56	1,022.10	-	2,335.46
1.2.6	Үйл ажиллагаа сурталчлах	6,957.24	5,491.32	-	1,465.92
1.2.7	Томилот	12,974.36	7,668.44	-	5,305.92
	Үйл ажиллагааны зардлын дүн	135,223.50	17,696.74	-	117,526.76
1.3.1	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	7,723.12	0.00	-	7,723.12
	Байгаль орчны зардлын дүн	7,723.12	0.00	-	7,723.12
2	Хайгуулын ажлын зардлын дүн (1.1+1.2+1.3)	862,091.34	59,746.54	-	802,344.80
3.1	Эхний 5 сая ам.дол 5%	43,104.57	2,987.33	-	40,117.24
3	Захиргааны зардлын дүн	43,104.57	2,987.33	-	40,117.24
4	ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН НИЙТ ДҮН	905,195.91	62,733.87	-	842,462.04



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Хавсралт 3

Тахь ресурс ХХК-ийн “Онги V” талбайн ӨНЗ

/ам.доллар/

№	Зардлын ангилал, төрөл	Гэрээлэгчийн тайлагнасан ӨНЗ-ын дүн	Аудитаар хасагдсан зардал	Аудитаар нэмэгдсэн зардал	2023 оны баталгаажсан ӨНЗ
1	2	3	4	5	6
1.1.1	Геологийн мэдээллийн сан бүрдүүлэлт, тайлалт, менежмент	71,241.43	60,000.00	-	11,241.43
1.1.2	Өрөмдлөгийн ажлын зардал	243,780.00	-	-	243,780.00
1.1.3	Цооногийн геофизикийн ажил	36,648.00	-	-	36,648.00
1.1.4	Цооногийн туршилт(IFOT)	27,511.00	-	-	27,511.00
1.1.5.1	Техникийн бүрэн шинжилгээ	2,659.57	-	-	2,659.57
1.1.5.2	Мацерал, Витринитийн шинжилгээ	6,566.01	517.57	-	6,048.44
1.1.5.3	Хийн шинжилгээ	49,396.82	-	-	49,396.82
1.1.7	Болзошгүй эрсдэлийн зардал	15,829.86	5,013.76	-	10,816.10
	Хайгуулын ажлын зардлын дүн	453,632.69	65,531.33	-	388,101.36
1.2.1	Цалингийн зардал	37,579.03	403.67	-	37,175.36
1.2.2	Бичиг хэргийн зардал	2,084.79	1,684.79	-	400.00
1.2.3	Тээвэр	11,728.08	-	-	11,728.08
1.2.4	Бараа материалын худалдан авалт	42,166.48	1,084.60	-	41,081.88
1.2.5	ХАБЭА зардал	2,371.45	36.00	-	2,335.45
1.2.6	Үйл ажиллагаа сурталчлах	3,478.62	2,745.65	-	732.97
1.2.7	Томилот	9,324.85	7,329.24	-	1,995.61
	Үйл ажиллагааны зардлын дүн	108,733.30	13,283.95	-	95,449.35
1.3.1	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	15,347.61	4,717.68	-	10,629.93
	Байгаль орчны зардлын дүн	15,347.61	4,717.68	-	10,629.93
1	Тухайн жилийн Хайгуулын ажлын зардлын дүн	577,713.60	83,532.96	-	494,180.64
1.4.1	Өрөмдлөг-Стратиграфийн цооног RC	91,107.00	-	-	91,107.00
1.4.2	Өрөмдлөг-Кернтэй өрөмдлөг	100,785.00	-	-	100,785.00
1.4.3	2022 оны дүгнэлт	32,000.00	-	-	32,000.00
1.4.4	Цооногийн геофизикийн судалгаа	29,364.00	-	-	29,364.00
	Өмнөх оны төлөвлөгөө, төсөв дэх ажилд зарцуулсан дүн	253,256.00	-	-	253,256.00
2	Хайгуулын ажлын зардлын дүн (1.1+1.2+1.3)	830,969.60	83,532.96	-	747,436.64
3.1	Эхний 5 сая ам.дол 5%	39,948.48	2,576.65	-	37,371.83
3	Захиргааны зардлын дүн	39,948.48	2,576.65	-	37,371.83
4	ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН НИЙТ ДҮН	870,918.08	86,109.61	-	784,808.47



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Хавсралт 4

Тэлмэн ресурс ХХК-ийн “Гурвантэс ХХХV” талбайн ӨНЗ

/ам.доллар/

№	Зардлын ангилал, төрөл	Гэрээлэгчийн тайлагнасан ӨНЗ-ын дүн	Аудитаар хасагдсан зардал	Аудитаар нэмэгдсэн зардал	2023 оны баталгаажсан ӨНЗ
1	2	3	4	5	6
1.1.1	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ	6,661.67	3,732.10		2,929.57
1.1.2	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал	4,738.33	86.15		4,652.18
1.2.1	2 хэмжээст чичирхийллийн судалгаа	132,409.16	21,468.24		110,940.92
1.2.2	Цооногийн каротаж	13,006.56	218.21		12,788.35
1.3.1.1	Өрөмдлөг	165,331.70	165,331.70		0.00
1.3.1.2	Цооногийн туршилт	129,645.29	129,645.29		0.00
1.3.2.1	Анги нүүлгэлт, татан буултын нэгдсэн зардал	255,783.97	0		255,783.97
1.3.2.2	Туршилт-олборлолтын өрөмдлөгийн зардал	1,533,717.21	822,417.21		711,300.00
1.4.1	Нүүрсний чанар (нягт, үнс, чийг, дэгдэмхий нэгдэл), үлдэгдэл хийн (Q3) шинжилгээ	7,703.70	0		7,703.70
1.4.2	Хийн найрлагын шинжилгээ	1,011.60	0		1,011.60
1.4.3	Хийн адсорбц, витринит, петрографын шинжилгээ	405.28	0		405.28
1.4.4	Туршилт-олборлолтын цооногийн шавхалтын усны найрлагын шинжилгээ	332.88	0		332.88
2.1	Усны шугам хоолой байгуулалт	75,351.03	34,753.03		40,598.00
2.2	Цооног хоорондын ус цуглуулах бассейн байгуулалт	115,205.82	38,058.82		77,147.00
2.3	Ажилчдын кэмп байгуулах зардал	349,070.02	11,151.48		337,918.54
2.4	Хөдөлгөөнт лаборатори байгуулах зардал	1,196.52	42.44		1,154.08
	Дүн (27+28...+30)	2,791,570.74	1,226,904.67		1,564,666.07
3.1	Катерингийн үйлчилгээ	354,667.54	137,166.35		217,501.19
3.2	Харуул хамгаалалтын зардал	36,607.18	3,505.18		33,102.00
3.3	Шатахууны зардал	27,383.24	7,382.84		20,000.40
3.4	Эрчим хүчний хангамж (дизель генератороор)	117,488.35	0		117,488.35
3.5	Ачаа тээвэр	11,454.65	456.7		10,997.95
3.6	Машин түрээс (Хүн тээвэр)	30,823.83	260.4		30,563.43
3.7	Усны машин	21,530.98	0		21,530.98
3.8	Дизель генератор түрээс	60,584.72	28,940.28		31,644.44
3.9	Ажилчдын цалин	334,593.87	0		334,593.87
3.1	Томилолтын зардал	6,962.68	3,762.68		3,200.00
3.11	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэрэгслийн зардал	27,844.35	1,636.57		26,207.78



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

3.12	Бараа материалын худалдан авалт	762,363.65	2,374.00		759,989.65
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,792,305.04	185,485.00	0.00	1,606,820.04
Σ	Тухайн жилийн нийт дүн (1+2+3+4)	4,583,875.78	1,412,389.67	0.00	3,171,486.11
5	Өмнөх оны төлөвлөгөө, төсөв дэх ажилд зарцуулсан дүн	29,861.98	0		29,861.98
5.1.	2 хэмжээст чичирхийллийн судалгаа 2022	26,400.91	0		26,400.91
5.2.	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ 2022	3,461.07	0		3,461.07
Σ	Нийт дүн (1+2+3+4+5)	4,613,737.76	1,412,389.67	0.00	3,201,348.09
6	Захиргааны зардал	230,686.89	70,750.12		159,936.77
	Эхний 5 сая ам.дол 5%	230,686.89	70,750.12		159,936.77
	Дараагийн 5 сая ам.дол 3%		0		0.00
Σ	ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН НИЙТ ДҮН	4,844,424.65	1,483,139.79	0.00	3,361,284.86



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Хавсралт 5

Жи Өү Эйч ХХК-ийн "Номгон IX" талбайн ӨНЗ

/ам.доллар/

№	Зардлын ангилал, төрөл	Гэрээлэгчийн тайлагнасан ӨНЗ-ын дүн	Аудитаар хасагдсан зардал	Аудитаар нэмэгдсэн зардал	2023 оны баталгаажсан ӨНЗ
1	2	3	4	5	6
A.1.04.01	Байгаль орчны нөхөн сэргээлт (хайгуулын)	37,030.78	9,137.02	-	27,893.76
A.1.04.02	Байгаль орчин хамгаалах менежмент (тайлан төлөвлөгөө, боловсруулах)	18,607.20	-	-	18,607.20
A.1.01	Геологийн зураглал 1:25000	40,355.30	40,355.30	-	-
A.3.05.01	Хайгуулын / Үнэлгээний цооног	1,619,647.45	485,647.45	-	1,134,000.00
A.3.05.03	Туршилтын/олборлолтын цооног	1,152,539.46	541,986.38	-	610,553.08
A.3.04.01	Цооногийн геофизик	95,771.57	-	-	95,771.57
A.3.05.04	Явуулын хийн шинжилгээ	65,471.90	14,371.90	-	51,100.00
A.3.09	Цооногийн давхаргын туршилт	120,630.59	20,630.59	-	100,000.00
A.6.01	Лабораторийн ажил	12,823.66	1,983.66	-	10,840.00
4.1.1	Дүн	3,162,877.91	1,114,112.30	-	2,048,765.61
A.4.01	Цалин	127,918.46	898.44	-	127,020.02
A.4.02	НДШ	15,989.81	687.46	-	15,302.35
A.4.03	Томилолт	15,169.77	620.22	-	14,549.55
A.4.09	бусад	100,358.53	358.53	-	100,000.00
	Үйл ажиллагааны зардлын дүн	259,436.57	2,564.65	-	256,871.92
∑	Тухайн жилийн нийт дүн (1+2+3+4)	3,422,314.48	1,116,676.95	-	2,305,637.53
5	Өмнөх оны төлөвлөгөө, төсөв дэх ажилд зарцуулсан дүн	381,637.96	287,446.92	-	94,191.04
A.3.05.01-2022	Хайгуулын / Үнэлгээний цооног	381,637.96	287,446.92	-	94,191.04
∑	Нийт дүн (1+2+3+4+5)	3,803,952.44	1,404,123.87	-	2,399,828.57
	Эхний 2 сая ам.дол 5%	172,158.10	40,171.82	-	131,986.28
	Дараагийн 3 сая ам.дол 4%		15,993.13	-	(15,993.13)
	Захиргааны зардлын дүн	172,158.10	56,164.95	-	115,993.15
∑	ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН НИЙТ ДҮН	3,976,110.54	1,460,288.82	-	2,515,821.72



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Хавсралт 6

Смарт-Ойл Монголиа ХХК-ийн “Эргэл XII” талбайн ӨНЗ

/ам.доллар/

№	Зардлын ангилал, төрөл	Гэрээлэгчийн тайлагнасан ӨНЗ-ын дүн	Аудитаар хасагдсан зардал	Аудитаар нэмэгдсэн зардал	2023 оны баталгаажсан ӨНЗ
1	2	3	4	5	6
1.1.3	3 хэмжээст чичирхийллийн судалгааны хээрийн ажил, хээрийн боловсруулалт, топогеодезийн ажил, суурин боловсруулалт, тайлал (энэ дүнд НӨАТ-ын 10% багтсан)	544,847.81	388,921.65	-	155,926.16
	Чичирхийллийн судалгааны зардлын дүн (1.1)	544,847.81	388,921.65	-	155,926.16
1.4.1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, Орчны хяналт шинжилгээ, үнэлгээний хөтөлбөр хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн тайлан гаргах, талбайг орон нутагт хүлээлгэн өгөх зардал	12,800.00	0.00	-	12,800.00
1.4.2	Хайгуулын үйл ажиллагааны үед байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал	48,000.00	0.00	-	48,000.00
	Байгаль орчны ажлын зардлын дүн (1.4)	60,800.00	0.00	-	60,800.00
2.1	Хээрийн суурин кэмп барьж байгуулах болон кэмп зохион байгуулалтын зардал	237,941.96	144,146.27	-	93,795.69
2.2	Хайгуулын ажлын гадаад мэргэжилтнүүдийн виз, оршин суух зөвшөөрөл, даатгал, эрүүл мэндийн үзлэг, бусад зардал	99,833.63	17,701.40	-	82,132.23
2.4	Тээврийн хэрэгсэл (автомашин худалдан авах)-ийн зардал	21,385.29	0.00	-	21,385.29
2.5	Кэмпийн оффисийн хангамж, тавилга, техник хэрэгсэлийн зардал	2,290.50	0.00	-	2,290.50
2.6	Кэмпийн харуул хамгаалалтын зардал	25,952.36	0.00	-	25,952.36
2.7	Үйл ажиллагааны бусад зардал (төрийн байгууллага, орон нутагтай харилцах, хурал уулзалт, томиллолт, бусад)	7,941.79	0.00	-	7,941.79
	Үйл ажиллагааны зардлын дүн (2)	395,345.53	161,847.67	-	233,497.86
	2 хэмжээст чичирхийллийн судалгааны ажлын дутуу төлбөр /2022 он/	1,206,796.14	262,112.73	-	944,683.41
	Геологи, геоморфологийн судалгаа /2022 он/	15,000.00	0.00	-	15,000.00
	Өмнөх оны төлөвлөгөө, төсөв дэх ажилд зарцуулсан дүн	1,221,796.14	262,112.73	-	959,683.41
	Тухайн жилийн өртөг нөхөгдөх зардлын дүн (I+II+III)	2,222,789.48	812,882.05	-	1,409,907.43
	Эхний 10 сая ам.дол 5%	42,265.00	0.00	28,230.37	70,495.37
	Захиргааны зардлын нийт дүн	42,265.00	0.00	28,230.37	70,495.37
Σ	Өртөг нөхөгдөх зардлын нийт дүн(I+II+III+IV)	2,265,054.48	812,882.05	28,230.37	1,480,402.80



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Хавсралт 7

Монголын Алт (МАК) ХХК-ийн “Төхөм-Х урд” талбайн ӨНЗ

/ам.доллар/

№	Зардлын ангилал, төрөл	Гэрээлэгчийн тайлагнасан ӨНЗ-ын дүн	Аудитаар хасагдсан зардал	Аудитаар нэмэгдсэн зардал	2023 оны баталгаажсан ӨНЗ
1	2	3	4	5	6
1.1	Цооногийн өрөмдлөгийн болон геологийн дизайн гаргах	44,500.00	0.00	-	44,500.00
1.2	Өрмийн нүүдэл тээвэр, анги зохион байгуулалт, татан буулгалт	939,047.00	0.00	-	939,047.00
1.3	Хайгуулын цооног өрөмдөх	1,767,839.00	0.00	-	1,767,839.00
	Цалин, НДШ -ийн зардал	28,744.87	0.00	-	28,744.87
	Ажиллах хүч	482.24	482.24	-	0.00
	Материалын зардал	662.89	0.00	-	662.89
	Томилолт	6,394.84	1,388.70	-	5,006.14
	ҮА зардал	1,568.29	667.78	-	900.51
	Бусад зардал	645.32	645.32	-	0.00
	Өрмийн зөвлөх үйлчилгээ	164,489.94	164,489.94	-	0.00
	Өрмийн хяналт	11,411.43	11,411.43	-	0.00
1.4	Цооногийн чөмөг чулуун дээж авах	175,434.60	0.00	-	175,434.60
1.6	Цооногийн геофизикийн судалгаа /каротаж/	9,505.97	0.00	-	9,505.97
1.9	Цооногийн VSP хэмжилт	270,000.00	0.00	-	270,000.00
	Хайгуулын өрөмдлөгийн зардлын дүн	3,420,726.39	179,085.41	-	3,241,640.98
1.5	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн зардал		0.00	-	0.00
	Хайгуулын ажлын зардлын дүн	3,420,726.39	179,085.41	-	3,241,640.98
2	Бүтээн байгуулалтын зардал		0.00	-	0.00
3	Олборлолтын үйл ажиллагааны зардал		0.00	-	0.00
4	Татан буулгалтын зардал		0.00	-	0.00
∑	Тухайн жилийн нийт өртөг	3,420,726.39	179,085.41	-	3,241,640.98
5	Өмнөх оны төлөвлөгөө, төсөв дэх ажилд зарцуулсан дүн	162,287.07	0.00	-	162,287.07
	2D чичирхийллийн судалгаа 2022 оны ажил	162,287.07	0.00	-	162,287.07
∑	Нийт дүн	3,583,013.46	179,085.41	-	3,403,928.05
6	Захиргааны зардлын дүн	143,320.54	0.00	12,836.60	156,157.14
6.1	Эхний 5 сая ам.дол 5%	143,320.54	0.00	12,836.60	156,157.14
∑	ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН НИЙТ ДҮН	3,726,334.00	179,085.41	12,836.60	3,560,085.19



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Хавсралт 8

Шунхлай Энержи ХХК-ийн “Сүлэнхээр ХХХIII” талбайн ӨНЗ

/ам.доллар/

№	Зардлын ангилал, төрөл	Гэрээлэгчийн тайлагнасан ӨНЗ-ын дүн	Аудитаар хасагдсан зардал	Аудитаар нэмэгдсэн зардал	2023 оны баталгаажсан ӨНЗ
1	2	3	4	5	6
1.23	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний урьдчилгаа төлбөр 40% Грийн сольюшн консалтинг ХХК гэрээний дугаар 23/02-03	7,422.10		-	7,422.10
1.23.1	Газрын хянан баталгааны урьдчилгаа төлбөр 40% Тод байгаль ХХК гэрээний дугаар 01/Б	1,712.79		-	1,712.79
1.23.2	БОННУ гэрээний төлбөр	5,538.72		-	5,538.72
1.24	Цалин 2-р сарын урьдчилгаа	2,081.62		-	2,081.62
1.24.1	2-р сарын цалин	421.03		-	421.03
1.24.2	НДШ төлсөн 2-р сар	629.38		-	629.38
1.24.3	qrау 20000234901009 1150414064651 2698 5102685	272.95		-	272.95
1.24.4	ЕВ -2023 оны 3-р сарын урьдчилгаа цалин	1,275.73		-	1,275.73
1.24.5	2023 ОНЫ 3-Р САРЫН ЦАЛИН	1,457.25		-	1,457.25
1.24.6	НДШ төлсөн 3-р сар	702.27		-	702.27
1.24.7	Цалин 4-р сарын урьдчилгаа	1,286.20		-	1,286.20
1.24.8	4-р сарын цалин	1,474.53		-	1,474.53
1.24.9	ЕВ -5102685 Шунхлай Энержи ХХК НДШ 4 сар	713.28		-	713.28
1.24.10	499182566 БАТ-ОРШИХ ГАЛБАДРАХ -5-р сарын урьдчилгаа цалин	433.04		-	433.04
	Эхний 5 сая ам.дол 5%	1,271.04	1,271.04	-	-
Σ	Нийт дүн	26,691.92	1,271.04	-	25,420.88



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Хавсралт 9

Капкорп Монголиа ХХК-ийн “Онги V” талбайн ӨНЗ

/ам.доллар/

№	Зардлын ангилал, төрөл	Гэрээлэгчийн тайлагнасан ӨНЗ-ын дүн	Аудитаар хасагдсан зардал	Аудитаар нэмэгдсэн зардал	2023 оны баталгаажсан ӨНЗ
1	2	3	4	5	6
1.1.2	Байгаль орчны мониторингийн хөтөлбөр - Велосираптор-1 цооногийн өрөмдлөгийн явцад, өрөмдлөгийн дараа	2,894.72	-	-	2,894.72
1.1.3	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тодотгол	3,246.68	-	-	3,246.68
1.1.4	Гамшгийн эрсдлийн нарийвчилсан үнэлгээ	4,810.01	-	-	4,810.01
1.1.5	Велосираптор-1 цооногийн техникийн болон биологийн нөхөн сэргээлт	23,012.02	-	-	23,012.02
1.1.6	Яаралтай үед агаараар нүүлгэн шилжүүлэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	4,394.06	4,394.06	-	-
1.1.7	Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл	2,792.03	2,792.03	-	-
1.3.1.1	Өрөмдлөгийн цамхаг, тоног төхөөрөмжийн нүүлгэлт	55,000.00	-	-	55,000.00
1.3.1.2	Өрөмдлөгийн цамхаг, тоног төхөөрөмжийн буцаан нүүлгэлт	55,000.00	-	-	55,000.00
1.3.2.1	Кэмпийн нүүлгэлт	16,995.00	-	-	16,995.00
1.3.2.2	Кэмпийн буцаан нүүлгэлт	16,995.00	-	-	16,995.00
1.3.2.3	Өрөмдлөгийн талбайн бэлтгэл	35,704.42	5,704.42	-	30,000.00
1.3.2.4	Өрөмдлөг (бэхэлгээний яндан суулгах, цементлэх ажил багтсан)	930,389.63	306,689.63	-	623,700.00
1.3.2.5	Өрөмдлөгийн идэвхтэй цагийн төлбөр	150,078.50	52,266.50	-	97,812.00
1.3.2.6	Өрөмдлөгийн идэвхгүй цагийн төлбөр	19,731.26	-	-	19,731.26
1.3.2.7	Өрөмдлөгт ашиглах бараа материал өрөмдлөгийн шаврын бодисууд, цемент, чиглүүлэгч болон амсрын бэхэлгээний яндан)	224,656.31	59,125.31	-	165,531.00
1.3.2.8	Эмч, түргэний машин (жолоочтой)	12,540.91	9,240.91	-	3,300.00
1.3.2.9	Кэмпийн хангалт болон түүний үйл ажиллагаа	72,230.71	8,720.71	-	63,510.00
1.3.2.10	Зочид болон түр хугацааны ажилчдын хоол	2,954.63	-	-	2,954.63
1.3.2.11	Нэмэлт сууц (4 гэр х 10 хоног)	2,519.75	919.75	-	1,600.00
1.3.3	Велосираптор-1 цооногийн каротаж	229,895.54	2,515.79	-	227,379.75
1.3.4.1	Шаврын бичиглэлийн тоног төхөөрөмж	1,618.35	-	-	1,618.35
1.3.5.1	Техникийн ус болон хог хаягдал	20,237.10	15,737.10	-	4,500.00
1.3.5.2	Даатгал	56,222.93	56,222.93	-	-
1.3.5.3	Өрөмдлөгийн хяналт, удирдлагын зардал	11,896.18	-	-	11,896.18



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

1.3.6	Велосираптор-1 цооногийн ерөмдлөгийн дараах судалгаа	7,362.52	7,362.51	-	0.01
	Дүн	1,963,178.26	531,691.65	-	1,431,486.61
1.4.1	Техникийн ажилчдын цалин болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	51,539.50	17,392.94	-	34,146.56
1.4.2	Үйл ажиллагаанд хамаарах бусад зардал	44,439.77	15,751.26	-	28,688.51
	Үйл ажиллагааны зардал	95,979.27	33,144.20	-	62,835.07
	Хайгуулын ажлын зардлын дүн	2,059,157.53	564,835.85	-	1,494,321.68
2	Захиргааны зардлын дүн:	40,894.02	-	33,822.06	74,716.08
2.1	Эхний 5,000,000 ам.долларт - 5%	40,894.02	-	33,822.06	74,716.08
	ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН ДҮН	2,100,051.55	564,835.85	33,822.06	1,569,037.76



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал:

№	Тайланд ирүүлсэн АМГТГ-ын санал	ҮАГ-ын тайлбар
1	Санал1.1: ...тайлангийн төсөлд Капкорп Монголиа ХХК хайгуул үнэлгээний хөрөнгийн дансны үлдэгдлийг тайлант үеийн алдагдлаар хүлээн зөвшөөрч, санхүүгийн тайландаа засвар оруулснаар зөрүү үүссэн байна, харин Капкорп Монголиа ХХК нь манайд ирүүлсэн санхүүгийн тайландаа ХҮХД-ны үлдэгдлийг хүлээн зөвшөөрч, тайлант үеийн алдагдлаар хүлээн зөвшөөрөөгүй байсан.	АМГТГ-аас 2025 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр khoroalsuren.t@mrpam.gov.mn хаягаас ирүүлсэн Капкорп монголиа ХХК-ийн 2023 оны баталгаажсан санхүүгийн тайланд хайгуул үнэлгээний хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл "тэг" байна. ГТТХ-ийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх заалтын дагуу АМГТГ-ын хянан шалгаж, дүгнэлт гаргасан тайланд Капкорп Монголиа ХХК -ний "Хайгуул үнэлгээний хөрөнгө" дансны мэдээллийг нягталж шалгаагүй буруу тайлангийн дүн нэгтгэсэн тул саналыг хүлээж авах боломжгүй байна.
2	Санал1.2.1: ...жилийн ажлын уулзалтыг 2023 оны 01 дүээр сарын 17-ноос 03 дугаар сарын 28-ны хооронд 14 гэрээлэгч зохион байгуулсан, жилийн уулзалтаар 10 гэрээлэгчийн 12 талбайн 2023 оны БХГ-ний хэрэгжилтийг хэлэлцсэн. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төсөв гэж байхгүй.	Тайлангийн төсөл дэх найруулгын саналыг хүлээж авлаа.
3	Санал1.2.2: Макс ойл ХХК нь Байгаль орчны яам, Эрдэнэцагаан сумын удирдлагуудад удаа дараа хандсан боловч БОННУТ батлуулах асуудал шийдэгдээгүй хэвээр байна, Чайна голден сий петролиум эксплорейшн корпорейшн ХХК -т 2023 оны төлөвлөгөө засварт буцаасан засвар хийж дахин ирүүлээгүй, ЗонХэнЮуТиан ХХК нь 2023 онд 2 цооног өрөмдөх ажилд 4.2 сая доллар зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгээгүй, албан бичиг хүргүүлсэн хариу тайлбар байхгүй байна, Тахь ресурс ХХК-ийн Т1 талбайд сумын иргэд болон ТББ жагсаалтаас болж БОННУ тайлан хүчингүй болж хайгуулын үйл ажиллагаа зогссон. гэрээний үүргээ бүрэн биелүүлээгүй, төлөвлөгөө, төсөв батлуулсан ч үйл ажиллагаа явуулаагүй гэрээлэгчид тодорхой арга хэмжээ авч ажилласан.	Чайна голден сий петролиум эксплорейшн корпорейшн ХХК нь хөрөнгийн эх үүсвэргүй шалтгаанаар тухайн жилийн төлөвлөгөө, төсөв батлуулаагүй, Макс ойл ХХК нь орон нутгийн удирдлага болон иргэд, ТББ-ын эсэргүүцлээс шалтгаалан хайгуулын ажлаа хийж чадаагүй нь орон нутгийн удирдлага газрын тосны тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, орон нутгийн эрх хэмжээний асуудлыг шийдвэрлэхдээ улсын ашиг сонирхлыг харгалзан, бодлого шийдвэрээ төрийн бодлоготой уялдуулаагүй, хуулийн хэрэгжилтийг хангаагүйгээс гэрээлэгч БХГ-ээр хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй байна. Энэ нь ГТТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.3, 10 дугаар зүйлийн 10.1.1 , 10.4.4 дэх заалттай тус тус нийцэхгүй байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
4	Санал1.2.3: ... Гурвантэс сумын Баясах багийн Иргэдийн нийтийн хурлын тогтоол гараагүй улмаас БОННУ-ний тодотголын ажил тодорхойгүй хугацаагаар хойшилсон тул гэрээлэгч 2023 оны төлөвлөгөө, төсөвт тусгагдаагүй туршилт-олборлолтын ажлыг хийсэн, манайх ӨНЗ-аас хасах санал гаргаж хассан.	Саналыг хүлээн авч, тайланд засвар оруулав. 1.2.3: өгүүлбэрт найруулга орууллаа.
5	Санал1.3: АМГТГ-ын хяналт шалгалтаар хасагдсан 4,680,817.93 ам долларын өртөг нөхөгдөх зардлын дүнг баталгаажуулалтын тайланд тусгуулах саналтай байна.	ГТТХ-ийн 37 дугаар зүйлийн 37.2, ГТБТЖ-ын 11.9-д төрийн аудитын байгууллага төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн тайлан, дүгнэлтэд холбогдох тайлбар, нотлох баримтад үндэслэн хянан шалгаж, дүгнэлтийг эцэслэн баталгаажуулах талаар заасан. Тиймээс нотлох баримтад үндэслэн гэрээлэгч тус бүрд асуудлын бүртгэлээр танилцуулж, 4,944,502.44 ам.долларыг өртөг нөхөгдөх зардлаас хасаж баталгаажуулсан тул саналыг хүлээж авах боломжгүй байна.
6	Тайлангийн төслийн 1.3.2-ийн 5,8: ГТБТЖ-ын 3 дугаар бүлгийн 3.1.7 дах заалтад хамаарахгүй Смарт ойл Монголиа ХХК, Тэлмэн ресурс ХХК, Монголын алт (МАК) ХХК 83,073.10 ам.долларыг хассаныг хүлээн зөвшөөрөхгүй. Дээрх зардал нь ГТБТЖ 2.1.1 дэх хэсэгт хамаарах гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтийн зардал, НББОУС 16 стандартын дагуу олж бэлтгэх зардал үндсэн хөрөнгийн өртөгт орно. ГТБТЖ 2.1.2 дахь хэсэгт	1. Смарт-Ойл Монголиа ХХК-ийн ГТБТЖ 3.1.7, 3.1.23 дахь заалтад хамаарах 71,784.1 ам долларын ӨНЗ-с хасах дүнгийн 54,082.7 ам.долларыг аудитаар илрүүлсэн, харин 17,701.4 ам.долларыг АМГТГ-ын дүгнэлтээр ӨНЗ-с хасаж баталгаажуулахаар тайлангийн төсөлд оруулсан. <u>Аудитаар тогтоосон 54,082.7 ам.долларын зардалд дараах зардлууд орж байна.</u> Үүнд: 1.1 Хог хаягдлын хураамжид төлсөн 523.66 ам доллар



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

	<p>тусгай зориулалтын машин, тээврийн хэрэгсэл ӨНЗ-д орох талаар заасан тул дээрх татвар, хураамжийн зардал нь ӨНЗ-д орох нь зөв юм. Жи Өү Эйч ХХК-ийн 11,583.38 ам.долларыг журмын дагуу хийгдсэн ажил тул өртөг нөхөгдөх зардалд тооцно. Өмнөх аудитын баталгаажуулалтын тайлангуудад тус зардлууд өртөг нөхөгдөх зардалд тооцохоор баталгаажуулсан байдаг. Ийнхүү хуулийг өөр өөрөөр тайлбарлаж байгаа нь хөрөнгө оруулагч нарт хууль, эрх зүйн орчны тогтворгүй, ойлгомжгүй байдлыг үүсгэж байна.</p>	<p>нь Монгол улсын татварын нэг төрөл тул ӨНЗ-д орохгүй; 1.2 ГТБТЖ-ын 3 дугаар заалтын 3.1.2-т аккруэл суурийн дагуу бүртгэсэн боловч төлөгдөөгүй аливаа зардал ӨНЗ-д орохгүй гэсэн тул 155,684.61 ам долларын 9 пикап машиныг ӨНЗ-д оруулаагүй байна. Харин уг машиныг оруулж ирэхэд төлсөн даатгал, гаалийн татвар, хураамжийн 21,214.73 ам.долларын зардлыг үндсэн хөрөнгийн өртөгт шингээн бүртгэлгүй, шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байгаа тул ӨНЗ-д орохгүй; 1.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд гадаад мэргэжилтнүүдийн ажлын байрны төлбөрт 32,344.31 ам.доллар төлсөн байна. Энэхүү ажлын байрны төлбөр нь ажил олгогч гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлсний төлөө хуульд заасан хэмжээгээр төлөх мөнгөн төлбөрийг хэлэх бөгөөд ГТБТЖ-ын 2 дугаар заалтын 2.1.1 /а-ж/-д заасан гадаадын иргэний хөдөлмөр эрхлэлтийн зардалтай холбоогүй төлбөр, хураамж тул ӨНЗ-д орохгүй. Тиймээс саналыг хүлээн авах боломжгүй байна.</p> <p>2. Жи Өү Эйч ХХК-ийн 11,583.38 ам.доллар нь тайлангийн 1.3.2 дахь хэсэгт хамаарахгүй, харин тайлангийн 2.2 дахь хэсэг буюу "БХГ-ний дагуу тайлант онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгч нар хууль тогтоомж, бүтээгдэхүүн хуваах гэрээний заалттай нийцэхгүй дараах асуудлууд байна" гэсэн хэсэгт тусгагдсан. Уг зардлыг аудитаар ӨНЗ-аас хасах санал оруулаагүй болно.</p>
8	<p>Тайлангийн төслийн 1.3.4, 1.3.5: БХГ-ний "В" хавсралтаар хайгуулын ажлыг хийж гүйцэтгэхээр ЗонХэнЮуТиан ХХК-ийн Галба XI талбай 48,875,000.00 ам.долларын гэрээ байгуулж, 53,950,112.09 ам.долларыг баталгаажуулсан, Чайна голденсий петролиум корпорэйшн ХХК - ийн Тариач XV талбай 30,974,000.00 ам.долларын гэрээ байгуулж, 2007-2011 онуудад өртөг нөхөгдөх зардалд 57,461,366.59 ам.долларыг баталгаажуулсан. Гэрээлэгчид бүх хөрөнгө оруулалтын эрсдэлээ бүрэн хариуцаж гэрээ байгуулсан гэрээт талбайд гэрээнд тусгагдсан хайгуулын ажлыг доод хэмжээг гүйцэтгэсэн нь баталгаажуулсан аудитын өртөг нөхөгдөх зардлын тайлангаар нотлогдож байна. Гэвч дахин баталгаажсан өртөг нөхөгдөх зардлаас хайгуулын ажлын доод хэмжээг тооцож хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгээгүй хөрөнгө гэж үзэн нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож шийдвэрлэсэн нь гэрээлэгчийг 2 дахин торгож байна. ГТГХ-ийн 32.2 хуулийн үндэслэлгүй төлбөрийн акт тогтоосон нь гэрээлэгчдийг санхүүгийн хүнд байдалд оруулж, олон улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд уг төлбөрийн актыг хөрөнгийн биржид нээлттэй ил тод мэдээлэх үүрэгтэй иймд хөрөнгө оруулагчид газрын тосны салбарт оруулах хөрөнгө оруулалтаа багасгаж, газрын тосны салбарт сөргөөр нөлөөлж гэрээлэгч нарт маш их хүндрэл эрсдэл учруулж байна.Иймд тухайн жилийн ажлын батлагдсан төлөвлөгөө, төсвийг бүтээгдэхүүн хуваах гэрээний хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгээгүй үндэслэлээр тогтоож байгаа төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөхгүй.</p>	<p>ГТГХ-ийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх заалтын дагуу АМГТГ-ын хянан шалгаж, дүгнэлт гаргасан 2022, 2023 оны тайланд үндэслэн ӨНЗ-д баталгаажуулалтын аудит хийсэн болно. Засгийн газрын 2019 оны 178 "Газрын тосны бүртгэл, тооцооны журам"-ын 7 дугаар зүйлийн 7.7. "Тухайн жилийн хайгуулын ажлын төлөвлөгөө нь бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан хайгуулын ажлын доод хэмжээнээс багагүй байна", БХГ-ын 7 дугаар зүйлийн 7.2.1-д "гэрээлэгч нь энэхүү гэрээний хавсралт "В"-д тодорхойлсноос багагүй хэмжээний ажлыг жил бүр хийж гүйцэтгэнэ", 7.3.3-д "гэрээлэгч нь тухайн жилд гүйцэтгэх хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгээгүй тохиолдолд Газрын тосны тухай хуульд заасан хариуцлага хүлээхээс гадна гүйцэтгээгүй ажилд ногдох зарцуулагдаагүй хөрөнгийг тухайн гэрээт жил дууссанаас хойш 30 (гуч) хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад төлнө" гэж тус тус заасны дагуу саналыг хүлээж авах боломжгүй.</p>
9	<p>Санал2.1.1: ГТГХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1, 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсэг, Орон нутгийн</p>	<p>2.1.1 дэх асуудлыг ӨНЗ-д оруулаагүй, ГТГХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.3.энэ хуулийн 10.1.2-т "заасан</p>



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

	<p>хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.3.3, 3.4.3 дах хэсэг, заасны дагуу тухайн аймаг, сумын нутгийн удирдлагын хэрэгжүүлэх асуудалд хамаарна. БХГ-ний дагуу ОНХСанд төвлөрүүлж байгаа урамшуулал нь газрын тосны хайгуулын ажилд зарцуулсан хөрөнгө бөгөөд өртөг нөхөгдөхгүй зардал юм.</p>	<p>хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг жил бүр газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан Засгийн газарт танилцуулах”, 10.1.6-д “газрын тосны тухай хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах” заалтыг хэрэгжүүлэх тул саналыг хүлээж авах боломжгүй.</p>
10	<p>Санал2.2.1: ...гэрээт талбайд худалдан авсан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн гаалийн хураамжийн төлбөрт төлсөн зардал нь өртөг нөхөгдөх зардалд тооцогдох бөгөөд НББОУС 16 стандартын дагуу бүртгэсэн байна.</p>	<p>НББОУС 16 нь Үндсэн хөрөнгийн бүртгэлийн арга хандлагыг тайлбарласан стандарт бөгөөд энэхүү стандарт нь бараа материалд хамааралгүй. Мөн ГТБТЖ-ын 2 дугаар зүйлийн 2.1.2-т ӨНЗ-д орох бараа материал, сэлбэг хэрэгслийг заасан бөгөөд эдгээр бараа нь Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.16-д газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зориулсан машин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тоноглол, түүхий эд, материал, химийн болон тэсрэх бодис, сэлбэг хэрэгслийг гаалийн албан татвараас чөлөөлнө гэсэн тул саналыг хүлээн авах боломжгүй.</p>
11	<p>Санал2.2.2: ГТБТЖ-ын “Өртөг нөхөгдөх зардал үл тооцох” 3 дугаар бүлгийн 3.1.7 дах хэсэг үндэслэлд гэрээт талбайн хайгуулын ажилтай холбогдон гарсан гадаадын иргэн ажиллагсадтай холбоотой хөдөлмөр эрхлэлтийн зардал, виз, оршин суух зөвшөөрөл, даатгал, эрүүл мэндийн үзлэг, гэрээт талбайн хог хаягдлын хураамж, ус ашигласны төлбөр зэрэг татварын албанд төлсөн үндэслэлээр хассаныг хүлээн зөвшөөрөхгүй</p>	
12	<p>Санал2.2.4: Монголын алт (МАК) ХХК нь манай газартай нүүрсний давхаргын метан хийн хайгуул,ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар БХГ байгуулаагүй болно.</p>	<p>Саналыг хүлээж авч аудитын тайланд залруулав.</p>
13	<p>Санал2.2.5: ...Тэлмэн ресурс ХХК-ны бүтээн байгуулалтын зардал нь хайгуулын ажилтай холбогдон гарах үндсэн хөрөнгө худалдан авах зардал бөгөөд туслан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, тендер зохион байгуулах шаардлагагүй төлөвлөгөө, төсөв батлуулахдаа үндсэн хөрөнгө худалдан авах зардлыг батлуулсан байсан.</p>	<p>Саналыг хүлээн авч, тайланд засвар оруулав.</p>
14	<p>Санал2.2.6: Смарт ойл Монголиа ХХК, Метангаз ресурс ХХК нь БХГ-ний 8.4.1-д заасан хамтарсан хороог байгуулах шаардлага үүсээгүй, хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулж ажилласан.</p>	<p>Маргаан үүссэн үед байгуулна гэсэн заалт байхгүй, БХГ байгуулсан өдрөөс 180 хоногийн дотор байгуулна гэсэн заалттай, маргаантай асуудал гарахаас урьдчилан сэргийлж БХГ-ний заалтыг хэрэгжүүлж мэргэжлийн хамтарсан хороог байгуулах нь зөв, гэрээлэгч нар хүлээн зөвшөөрсөн.</p>
15	<p>Смарт ойл Монголиа ХХК нь БХГ-ний 8 дугаар зүйлийн 8.2.6-д “Гэрээлэгч нь өөрийн зардлаар Монгол Улсын иргэдийг сургах, дадлага хийлгэх замаар газрын тосны аж үйлдвэрийн бүх шатны боловсон хүчин бэлтгэхэд анхаарч ажиллана” заасны дагуу Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 01/451 дүгээр албан бичгийг үндэслэн нийгмийн хариуцлагын хүрээнд тус сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын сургалтын төлбөрийг төлж гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Монголын алт (МАК) ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд “Орон нутгийн хүүхдүүдийн сурч боловсрох боломжийг нэмэгдүүлж, чанартай боловсролыг дэмжих” хүрээнд 2016 оноос хойш сургалтын тэтгэлэгт хөтөлбөр зарлаж байгаа бөгөөд 2023 оны Хичээлийн жилд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 5, Дорноговь аймгийн Даланжаргалан сумын 2, Дундговь аймгийн Баянжаргалан,</p>	<p>Тухайн аудитын хугацаанд хамааралгүй тул саналыг хүлээж авах боломжгүй байна.</p>



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

	Дэлгэрхангай сумын тус бүр 2, нийт 11 оюутанд 38.9 сая төгрөгийн сургалтын тэтгэлэг олгосон байна. (https://www.mak.mn/socialresponsibility)	
16	Санал2.2.8: Хайгуул, судалгааны ажлын явц, гадны улсад хийгдсэн боловсруулалт, тайлан ажлуудаас шалтгаалан с Смарт ойл монголиа ХХК-ний 2023 оны гурван хэмжээст чичирхийллийн судалгааны хээрийн ажлын тайлан, зохих заавар зөвлөгөөг өгч тайлан засуулахаар 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр 04 дүгээр сарын 2-ны өдөр 06 дугаар сарын 22-ны өдөр 10 дугаар сарын 16-ны өдөр 2025 оны 01 дүгээр сарын 28 өдөр тус тус албан бичгээр хүргүүлж ажилласан.	АМГТГ-ын дүгнэлтийг үндэслэсэн. Уул уурхайн сайдын 2015 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 49 дүгээр тушаалын хавсралт болох “ГАЗРЫН ТОС, УЛАМЖЛАЛТ БУС ГАЗРЫН ТОСНЫ ЭРЭЛ, ХАЙГУУЛ, АШИГЛАЛТЫН АНХДАГЧ БОЛОН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАНД ТАВИХ ШААРДЛАГА”-ын 15.1.9. Гэрээлэгч нь БХГ болон тухайн жилд төлөвлөсөн төлөвлөгөө, төсвийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын хэрэгжилтийн тайлангаа дараа оны 1 дүгээр сард багтаан Төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн байна” гэсэн заалтыг зөрсөн, АМГТГ нь энэ журмын 16 дугаар заалтыг мөрдлөг болгож ажиллах, саналыг хүлээж авах боломжгүй байна.
17	Санал2.2.9: Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1-дэх заалт нь ашиглалтын үйл ажиллагаанд хамаарах бөгөөд Монголын алт МАК ХХК, Метангаз ресурс ХХК, Тэлмэн ресурс ХХК, Смарт ойл монголиа ХХК нар нь газрын тосны хайгуулын үйл ажиллагаа эрхэлдэг тул дээрх заалтыг хэрэгжүүлэх үндэслэлгүй.	Байгалийн нөөц баялаг гэдэг нь ашигт малтмал ашиглах гэсэн үг биш бөгөөд ус, ургамал, ой, амьтан нь байгалийн нөөц баялаг юм. Хайгуулын компаниуд бүгд ус ашиглах дүгнэлт гаргуулан үйл ажиллагаагаа явуулсан байгаа нь өөрөө байгалийн нөөцийн нэг болох усыг ашигласан гэдэг тодорхойлолтод нийцэж байгаа учраас хуулийн дагуу хийлгэх ёстой иймд саналыг хүлээж авах боломжгүй байна.
18	Санал2.2.10: Жи Өү Эйч ХХК -ийн 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01/61 дугаартай албан бичгээр талбай буцаах хүсэлт гаргасны дагуу 11,583.38 ам.долларыг зарцуулсан нь журмын үндэслэлтэй тул ӨНЗ-д тооцно.	Жи Өү Эйч ХХК-ийн асуудал нь газар эзэмшигч буюу ашиглагч биш учир хуулийг мөрдөж ажиллана, ӨНЗ-аас хасаагүй, хуулийн нийцлийн асуудал юм. (АМГТГ-ын ... талбай буцаан өгөх, хүлээн авах журмыг холбогдох хуульд нийцүүлэн шинэчлэх) Саналыг хүлээн авах боломжгүй байна.
19	Санал2.2.11: ... БХГ-г хэрэгжүүлэхээр гэрээлэгчээс санал ирүүлсний дагуу АМГТГ-ын даргын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 1/5155 албан бичгээр мэргэжилтэн томилж шивэрлэсэн. АМГТГ-ын даргын 2022 оны дугаар сарын 03-ны өдрийн Б/109 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.4-т “агентлагийн сургалтын хөтөлбөр төлөвлөгөө гаргаж, албан хаагчийг сургалтад хамруулах, тэдний мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, давтан сургах асуудлыг холбогдох газар, хэлтэс, нэгжийн даргын саналыг харгалзан зохион байгуулах” заасан боловч байгууллагаас сургалтад хамруулах боломжгүй тул дээрх байдлаар шийдвэрлэсэн.	АМГТГ-ын мэргэжилтэн Цэрэнхандтай холбоотой, одоо үргэлжлүүлээд бас нэг мэргэжилтэн сурч байгаа АМГТГ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлж, ажиллах, саналыг хүлээж авах боломжгүй байна.
20	Санал2.2.12: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4.3 заалтыг гэрээлэгч байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангаж ажилсан.	Аудитын тайланд тусгасан зөрчлийг цаашид анхаарч ажиллах. Саналыг хүлээж авах боломжгүй байна
21	Санал2.2.13: Тахь ресурс ХХК-ний талбайд туслан гүйцэтгэгч Наран эрдэс ХХК-аар гүйцэтгүүлсэн геологийн мэдээлэл цуглуулах, структурын загварчлал, геологийн модель хийсэн тайланг ирүүлснийг АМГТГ хянаж хүлээн авсан боловч тус ажилд зарцуулсан зардлыг ГТБТЖ-ын 3.1.3 дах заалтыг үндэслэн ӨНЗ-аас хасаж тооцсон.	Аудитын тайлангийн төслийн 1 дүгээр бүлгийн 1.3.2 дахь хэсэгт ӨНЗ-аас хасагдах зардал, 2 дугаар бүлэгт хууль тогтоомжтой нийцэхгүй байгаа зөрчлийн талаар тус тус тусгасан. Саналыг хүлээж авах боломжгүй байна.
22	Санал2.2.14: АМГТГ нь ГТТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-т заасны дагуу гэрээлэгчийн хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг баталж түүний гүйцэтгэлд хяналт тавих	Тайлант онд Төрийн захиргааны байгууллагад уламжилсан бичгийг нотлох баримтаар ирүүлээгүй бөгөөд ГТТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.12-т “Хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгэх



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

	<p>үүргийнхээ дагуу дээрх компаниудын тухайн оны хайгуулын ажлын төлөвлөгөөг баталж ажилладаг бөгөөд тухайн харилцааг тусгайлан зохицуулсан ГТТХ-аар БХГ-ний хэрэгжилтийг дүгнэдэг. Бүтээгдэхүүн хуваах гэрээний үүргээ биелүүлээгүй гэрээлэгч нарт хариуцлага тооцуулахаар Төрийн захиргааны төв байгууллагад уламжилдаг.</p>	<p>үүргээ хоёр буюу түүнээс дээш удаа биелүүлээгүй тохиолдолд хайгуулын хугацааг сунгахгүй” заалтыг хэрэгжүүлээгүй 2016 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй ЗонХэнЮуТиан ХХК-ийн Галба XI талбайн тусгай зөвшөөрлийг 2026 он хүртэл сунгасан байна. Иймд саналыг хүлээж авах боломжгүй байна</p>
23	<p>Санал2.3: Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн актын үлдэгдэлд өгөх санал. Капкорп Монголиа ХХК 75,000 ам.доллар, Монголын алт МАК ХХК-ийн 113,079.7 ам.долларын төлбөрийг 2023 онд барагдуулсан. Шунхлай энерги ХХК-ийн АМГТГ, АҮЭБЯ-д холбогдох Шунхлай энерги ХХК-ийн нэхэмжлэлтэй байгаагаас актын төлбөр төлөгдөхгүй байгаа. Макс ойл ХХК-д АМГТГ-ын даргын 2025.01.28-ны өдрийн 3/406 дугаар "Төлбөр урамшуулал төлөх тухай" албан бичгээр мэдэгдсэн, Метангаз ХХК-ийн Таван толгой ХХХV талбайн 7,157.94 ам.долларыг 128/ШШ2024/0886 дугаар анхан шатны шүүхийн шийдвэрээр түдгэлзүүлсэн, Петроматад ХХК-ийн Матад ХХ талбайн 18,377.67 ам.долларыг Матад сумын ОНХС-д төвлөрүүлсэн, Тусгай зөвшөөрөл, төлбөр урамшууллыг тооцоо нийлэх, төлбөр төлөх талаар Макс ойл ХХК, Тахь ресурс ХХК, Монголын алт ХХК-д 2025.01.28-ны өдрийн 3/406, 3/399 дугаар албан бичгээр хүргүүлсэн, ... ҮАГ-с тавьсан акт, албан шаардлагын талаар гэрээлэгчдэд мэдэгдсэн, шаардлага хүргүүлсэн, ҮАГ-аас тогтоосон төлбөрийн акт нь хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн...</p>	<p>Аудитын тайланд барагдуулаагүй төлбөрийн акт, хэрэгжүүлээгүй албан шаардлага, зөвлөмжийн талаар дурдаж биелэлтийг хангаж ажиллахыг зөвлөсөн. Төрийн аудитын байгууллагаас гаргасан шийдвэрийг хуулийн үндэслэлгүй гэх мэт тайлбар ирүүлэх нь Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, хуулиар хүлээсэн чиг үүрэгт хөндлөнгөөс нөлөөлсөн агуулга бүхий асуудлаар хандахгүй байхыг зөвлөж байна. АМГТГ-аас ирүүлсэн саналд өмнө оны аудитаар Капкорп Монголиа ХХК 75,000 ам.доллар, Монголын алт МАК ХХК-ийн 113,079.7 ам.долларын хэрэгжилтийг тооцсон байтал дахин давхар ирүүлсэн байна.</p> <p>Төрийн аудитын байгууллагаас тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна. Иймд саналыг хүлээж авах боломжгүй байна</p>



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2025 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 261/А0160186

Улаанбаатар хот

СНАГ-2025/08-НА-НА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2023 оны хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Чайна голденсий петролиум эксплорэйшн корпорэйшн ХХК-ийн Тариан XV талбайд тухайн жилд гүйцэтгэх хайгуулын ажлын доод хэмжээ 2,156,000.00 ам.доллар буюу 7,353,447,640.00 төгрөг (долоон тэрбум гурван зуун тавин гурван сая дөрвөн зуун дөчин долоон мянга зургаан зуун дөчин төгрөг) -ийг гүйцэтгээгүй бөгөөд зарцуулагдаагүй хөрөнгийг төрийн захиргааны байгууллагад төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д "газрын тосны тухай хууль тогтоомж, Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах", 9.1.3-т "Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих, 11 дүгээр зүйлийн 11.2.1-т "Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг мөрдөж, гэрээнд заасан үүргээ биелүүлэх", БХГ-ний 7.2.3-д "Тухайн талбайн геологийн нөхцөл, хайгуулын ажлын үр дүнгээс шалтгаалан ажлын доод хэмжээний нэр төрөл өөрчлөгдөж болох боловч төлөвлөсөн хөрөнгө оруулалтын хэмжээ өөрчлөгдөхгүй", 7.3.3-т "Гэрээлэгч нь тухайн жилд гүйцэтгэх хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгээгүй тохиолдолд Газрын тосны тухай хуульд заасан хариуцлага хүлээхээс гадна гүйцэтгээгүй ажилд ногдох зарцуулагдаагүй хөрөнгийг тухайн гэрээт жил дууссанаас хойш 30 (гуч) хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад төлнө" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.4-т "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z:\Aki\2025\1212.SAG-1.Docx




Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

1. Тухайн жилд гүйцэтгээгүй хайгуулын ажлын доод хэмжээ 2,156,000.00 ам.доллар буюу 7,353,447,640.00 төгрөг (долоон тэрбум гурван зуун тавин гурван сая дөрвөн зуун дөчин долоон мянга зургаан зуун дөчин төгрөг) -ийг нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогыг 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ашигт малтмал газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Баянбаатар)-т хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Akt\2025\1212 SAG-1.Docx



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 262/А0160186

Улаанбаатар хот

СНАГ-2025/08-НА-НА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2023 оны хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зон Хэн Юу Тиан ХХК-ийн Галба XI талбайд тухайн жилд гүйцэтгэх хайгуулын ажлын доод хэмжээ 4,505,000.00 ам.доллар буюу 15,365,158,450.00 төгрөг (арван таван тэрбум гурван зуун жаран таван сая нэг зуун тавин найман мянга дөрвөн зуун тавин төгрөг) -ийг гүйцэтгээгүй бөгөөд зарцуулагдаагүй хөрөнгийг төрийн захиргааны байгууллагад төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д "газрын тосны тухай хууль тогтоомж, Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах", 9.1.3-т "Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих, 11 дүгээр зүйлийн 11.2.1-т "Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг мөрдөж, гэрээнд заасан үүргээ биелүүлэх", БХГ-ний 7.2.3-д "Тухайн талбайн геологийн нөхцөл, хайгуулын ажлын үр дүнгээс шалтгаалан ажлын доод хэмжээний нэр төрөл өөрчлөгдөж болох боловч төлөвлөсөн хөрөнгө оруулалтын хэмжээ өөрчлөгдөхгүй", 7.3.3-т "Гэрээлэгч нь тухайн жилд гүйцэтгэх хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгээгүй тохиолдолд Газрын тосны тухай хуульд заасан хариуцлага хүлээхээс гадна гүйцэтгээгүй ажилд ногдох зарцуулагдаагүй хөрөнгийг тухайн гэрээт жил дууссанаас хойш 30 (гуч) хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад төлнө" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.4-т "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" 4.2.3.8-д "төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230


Z:\Akt\2025\12\12 SAG-1.Docx



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

1. Тухайн жилд гүйцэтгээгүй хайгуулын ажлын доод хэмжээ 4,505,000.00 ам.доллар буюу 15,365,158,450.00 төгрөг (арван таван тэрбум гурван зуун жаран таван сая нэг зуун тавин найман мянга дөрвөн зуун тавин төгрөг) -ийг нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогыг 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ашигт малтмал газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Баянбаатар)-т хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Akt\2025\1212_SAG-1.Docx



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 1280/АД160186

Улаанбаатар хот

СНАГ-2025/08-НА-НА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2023 оны хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Тахь ресурс" ХХК-ийн гүйцэтгэх захирал нь өөрийн хувь эзэмшдэг, гүйцэтгэх захирлаар ажилладаг "Наран эрдэс" ХХК-тай 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр 2023/048 дугаартай "Зөвлөх үйлчилгээ"-ний гэрээ байгуулан гүйцэтгэлээр 90.000.00 ам.доллар буюу 314,599,200.00 төгрөг (гурван зуун арван дөрвөн сая таван зуун ерэн есөн мянга хоёр зуу) шилжүүлэхдээ худалдан авах үнэ тогтоогоогүй, санхүүгийн тайланд холбоотой талуудын тодруулгыг бүртгээгүй, сонирхлын зөрчилтэй ажил гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.6-д "Төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал) энэ хуулийн 55.2-т заасны дагуу эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоохдоо хараат бус үнэлгээний байгууллагын дүгнэлтийг ашиглаж болно", 84 дүгээр зүйлийн 84.4.4-т "шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр мэдэгдэх", 89 дүгээр зүйлийн 89.1-т "Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно", 92 дугаар зүйлийн 92.2-д "Сонирхлын зөрчилтэй хэлцлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг энэ хуулийн 55 дугаар зүйлд заасан журмын дагуу төлөөлөн удирдах зөвлөл тогтооно", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" 6 дугаар бүлэг Санхүүгийн тайлангийн тодруулга 22-т "НББОУС 24 Холбоотой талуудын тодруулга –д заасны дагуу толгой компанийн нэр, хэрэв хамгийн дээд хяналт тавигч тал нь ялгаатай бол тэрхүү хяналт тавигч компани, хувь хүний нэрийг, тэргүүлэх удирдлагын бүрэлдэхүүнд олгосон урт болон богино хугацааны тэтгэмж, ажил эрхлэлтийн дараах тэтгэмж, ажлаас халагдсаны тэтгэмж, хувьцаанд суурилсан төлбөр, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээг тодруулна" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26130

Z:\Alban Shaaridga\2025\1212\SAG-1.Docx




Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" 4.2.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хамаарал бүхий этгээдээс сонирхлын зөрчилтэй бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа Төлөөлөн удирдах зөвлөл эсвэл мэргэжлийн байгууллагаар үнэ тогтоолгох;
2. Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэхдээ холбоотой талуудын мэдээллийг үнэн зөв, бүрэн тайлагнах;
3. Дээрх зөрчлүүдийг давтан гаргахгүй байх, гэрээлэгчид тавих хяналтыг сайжруулж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Баянбаатар)-т хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 1281/А0160185

Улаанбаатар хот

СНАГ-2025/08-НА-НА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2023 оны хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тэлмэн групп ХХК нь Тэлмэн ресурс ХХК-ийн гүйцэтгэх захирлын эзэмшдэг компани бөгөөд КТП-ний угсрах, 250 ква болон 10кв-н агаарын шугамын ажлыг 356,292,109.00 төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулж Тэлмэн констракшин ХХК-ийн гүйцэтгэх захирал итгэмжлэлгүйгээр гарын үсэг зурж тамга дарсан, Тэлмэн групп ХХК нь цахилгааны ажил хийх тусгай зөвшөөрөлгүй тул Эрчимт цамхаг ХХК-тай дээрх ажлыг 75,180.73 ам.доллар буюу 256,418,154.00 төгрөг (хоёр зуун тавин зургаан сая дөрвөн зуун арван найман мянга нэг зуун тавин дөрөв) давхар гэрээлсэн нь Компанийн тухай хууль болон санхүүгийн тайланд холбоотой талуудын тодруулгыг бүртгээгүй ТУЗ болон эрх бүхий мэргэжлийн байгууллагаар худалдан авах үнэ тогтоолгоогүй, сонирхлын зөрчилтэй ажил гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.6-д "Төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал) энэ хуулийн 55.2-т заасны дагуу эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтооходоо хараат бус үнэлгээний байгууллагын дүгнэлтийг ашиглаж болно", 84 дүгээр зүйлийн 84.4.4-т "шийдвэр гаргахдаа, сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр мэдэгдэх", 89 дүгээр зүйлийн 89.1-т "Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно", 92 дугаар зүйлийн 92.2-д "Сонирхлын зөрчилтэй хэлцлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг энэ хуулийн 55 дугаар зүйлд заасан журмын дагуу төлөөлөн удирдах зөвлөл тогтооно", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" 6 дугаар бүлэг Санхүүгийн тайлангийн тодруулга 22-т "НББОУС 24 Холбоотой талуудын тодруулга –д заасны дагуу толгой компанийн нэр, хэрэв хамгийн дээд хяналт тавигч тал нь ялгаатай бол тэрхүү хяналт тавигч компани, хувь хүний нэрийг, тэргүүлэх удирдлагын бүрэлдэхүүнд олгосон урт болон богино хугацааны тэтгэмж, ажил эрхлэлтийн дараах тэтгэмж, ажлаас халагдсаны тэтгэмж, хувьцаанд суурилсан төлбөр, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээг тодруулна" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51 464230

Z:\Alban Shaardlaga\2025\0212 SAG-1.Docx



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" 4.2.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хамаарал бүхий этгээдээс сонирхлын зөрчилтэй бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа Төлөөлөн удирдах зөвлөл эсвэл мэргэжлийн байгууллагаар үнэ тогтоолгох;
2. Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэхдээ холбоотой талуудын мэдээллийг үнэн зөв, бүрэн тайлагнах;
3. Дээрх зөрчлүүдийг давтан гаргахгүй байх, гэрээлэгчид тавих хяналтыг сайжруулж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Баянбаатар)-т хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 1282/А0160136

Улаанбаатар хот

СНАГ-2025/08-НА-НА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2023 оны хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Метангаз ресурс ХХК нь Газрын тосны тухай хууль болон Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу байгаль орчны нөхөн сэргээх баталгаа 17,038.83 ам.доллар буюу 58,114,167.09 төгрөг (тавин найман сая нэг зуун арван дөрвөн мянга нэг зуун жаран долоон төгрөг есөн мөнгө) -ийг эскроу дансанд дутуу байршуулсан байна.

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.9-д "байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг жил бүр төлөвлөгөө батлагдсанаас хойш 60 хоногийн дотор Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулах", мөн БХГ-ний 12.5.2-т "Гэрээлэгч эсхүл оператор компани нь Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгт зориулсан төлбөрийг гэрээт жил эхэлснээс хойш 30 (гуч) хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад төлнө", 12.6.2-т "Гэрээлэгч эсхүл оператор компани орон нутгийг хөгжүүлэх урамшууллыг гэрээт жил эхэлснээс хойш 60 (жар) хоногийн дотор, цаашид санхүүгийн жил эхэлснээс хойш 30 (гуч) хоногийн дотор орон нутгийг хөгжүүлэх санд төвлөрүүлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" 4.2.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Байгаль орчны нөхөн сэргээх баталгааны дутуу 17,038.83 ам.доллар буюу 58,114,167.09 төгрөг (тавин найман сая нэг зуун арван дөрвөн мянга нэг зуун жаран долоон төгрөг есөн мөнгө) -ыг эскроу дансанд байршуулах;

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlagn\2025\1212 SAG-1.Docx



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

2. Байгаль орчныг нөхөн сэргээх баталгаа байршуулах болон БХГ-ний дагуу төлөх дэмжлэг, урамшууллыг төвлөрүүлэх хугацаа хоцроосон гэрээлэгчдэд зөрчлийг арилгах, хуулийн хугацааг мөрдөж байх;
3. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, гэрээлэгчид тавих хяналтыг сайжруулж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Баянбаатар)-т хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 1283/А0160186

Улаанбаатар хот

СНАГ-2025/08-НА-НА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2023 оны хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Смарт-Ойл Монголиа ХХК нь Газрын тосны тухай хууль болон Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу байгаль орчны нөхөн сэргээх баталгаа 610,887.80 ам.доллар буюу 2,083,548,910.58 төгрөг (хоёр тэрбум наян гурван сая таван зуун дөчин найман мянга есөн зуун арван төгрөг тавин найман мөнгө)-ийг эскроу дансанд байршуулаагүй байна.

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.9-д "байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг жил бүр төлөвлөгөө батлагдсанаас хойш 60 хоногийн дотор Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулах", мөн БХГ-ний 12.5.2-т "Гэрээлэгч эсхүл оператор компани нь Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгт зориулсан төлбөрийг гэрээт жил эхэлснээс хойш 30 (гуч) хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад төлнө" 12.6.2-т "Гэрээлэгч эсхүл оператор компани орон нутгийг хөгжүүлэх урамшууллыг гэрээт жил эхэлснээс хойш 60 (жар) хоногийн дотор, цаашид санхүүгийн жил эхэлснээс хойш 30 (гуч) хоногийн дотор орон нутгийг хөгжүүлэх санд төвлөрүүлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" 4.2.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгаль орчныг нөхөн сэргээх баталгаа гаргаагүй Смарт-Ойл Монголиа ХХК нь байгаль орчны нөхөн сэргээх баталгаа 610,887.80 ам.доллар буюу 2,083,548,910.58 төгрөг (хоёр тэрбум наян гурван сая таван зуун дөчин найман мянга есөн зуун арван төгрөг тавин найман мөнгө) -ыг эскроу дансанд байршуулах;

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-254230

Z:\Ulan Shandolgi\2025\12\25\2025-12-25\2025-12-25.docx




Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

2. Байгаль орчныг нөхөн сэргээх баталгаа байршуулах болон БХГ-ний дагуу төлөх дэмжлэг, урамшууллыг төвлөрүүлэх хугацаа хоцроосон гэрээлэгчдэд зөрчлийг арилгах, хуулийн хугацааг мөрдөж байх;
3. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, гэрээлэгчид тавих хяналтыг сайжруулж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Баянбаатар)-т хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН